

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Боловсролын зээлийн сангийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СНАГ-2025/020/НА-СТА-ЗГТС

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Улаанбаатар хот 2024 он</p>	<p>Санхүү-Нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 261663 Цахим хаяг: <a href="mailto:naranchimegts@audit.gov.mn">naranchimegts@audit.gov.mn</a> Аудитын менежер: Д.Энхдалай Утас: 260512 Цахим хаяг: <a href="mailto:enkhdalaid@audit.gov.mn">enkhdalaid@audit.gov.mn</a> Ахлах аудитор: А.Даваадорж Утас: 261628 Цахим хаяг: <a href="mailto:davaadorja@audit.gov.mn">davaadorja@audit.gov.mn</a></p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ .....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	9
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	11
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	12
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	13
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА .....	14
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа .....	14
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин .....	14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	14
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд .....	15
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	16
3.5.1 Төсвийн төлөвлөлт .....	16
3.5.2 Төсвийн гүйцэтгэл .....	16
3.5.3 Нэмэлт төсөв .....	17
4. АУДИТЫН ТАЙЛАН .....	18
4.1 Ерөнхий зүйл .....	18
4.2 Материаллаг байдал .....	18
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	18
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	18
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	19
4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд .....	19
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	23
4.5.1 Завсрын аудитын талаар .....	23
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн .....	24
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	24
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	25
5.1 Төлбөрийн акт .....	25
5.2 Албан шаардлага .....	25
5.3 Зөвлөмж .....	26
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .....	27

### Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160  
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,  
Цахим шуудан: info@audit.gov.mn,  
Цахим хуудас: www.audit.mn

БОЛОВСРОЛЫН ЗЭЭЛИЙН САНГИЙН  
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГЫН АЛБАН  
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  
О.СИЙЛЭГМАА ТАНАА

2025.02.25 № 07/716  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Боловсролын зээлийн сангийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

### Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн доорх зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй, Иргэний хуулийн 206 дугаар зүйлийн 206.1, 208 дугаар зүйлийн 208.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 дахь заалттай нийцээгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

- Сангаас хэрэгжүүлж байгаа тэтгэлгүүд Дэлхийн шилдэг их сургуулийн бакалаврын хөтөлбөр болон Сангийн санхүүжилтээр магистр, докторын сургалтад хамрагдаж, 6,352,208.0 мянган төгрөгийн зээл, тэтгэлэг авсан нийт 68 суралцагч гэрээний үүргээ зөрчсөн;
- Монгол Улсын Ерөнхийлөгчийн тэтгэлгээр 4,558,917.78 ам.доллар, 1,902,319.42 евро, 4,298,444.4 мянган төгрөгийн санхүүжилт авсан 205 суралцагчтай тооцоо нийлж баталгаажуулаагүй.

## **Аудитын гол асуудал**

Тайлант онд дотоодын болон гадаадын их, дээд сургуулиудад суралцаж буй оюутнуудад сургалтын төлбөрийн дэмжлэг, зээл, тэтгэлэг олгох, эргэн төлөлтийг хянах ажлууд хийгдсэн байна. Үүнд:

- Дотоодын их, дээд сургуулийн 16,261 суралцагчид 35,896,373.4 мянган төгрөгийн сургалтын төлбөрийн дэмжлэг, 2,108 суралцагчид 4,348,566.4 мянган төгрөгийн сургалтын төлбөрийн зээл олгосон;
- Засгийн газрын 2022 оны 346, 2024 оны 102 дугаар тогтоолын дагуу Ерөнхийлөгч болон Засгийн газрын тэтгэлгээр 2,117 суралцагчид 46,328,942.6 мянган төгрөгийн санхүүжилт, Дэлхийн шилдэг их сургуульд суралцаж буй 149 суралцагчид 11,970,679.1 мянган төгрөгийн зээл олгожээ.
- Эргэн төлөлтийн хүрээнд:
  - Оюутны хөгжлийн зээл авсан 47,062 суралцагчаас 11,528,507.4 мянган төгрөг,
  - Хөнгөлөлттэй зээл авсан 382 суралцагчийн 362,178.0 мянган төгрөг,
  - Гадаадад суралцах зээл авсан 42 суралцагчийн 2,579,287.7 мянган төгрөгийн зээл тус тус эргэн төлөгдсөн байна.

## **Бусад асуудлын хэсэг**

Засгийн газрын 2024 оны 102 дугаар тогтоолын хавсралтаар "Гадаадын болон дотоодын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид тэтгэлэг, зээл олгох, эргэн төлүүлэх, буцалтгүй тусламж олгох, дэмжлэг үзүүлэх журам", 103 дугаар тогтоолын хавсралтаар "Багш, багш мэргэжлээр суралцагч болон багш, ажилтны хүүхдийг тэргүүлэх, эрэлттэй мэргэжлээр суралцахад төрөөс дэмжлэг үзүүлэх журам"-ыг шинэчлэн баталсан байна.

## **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

## **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>301,027,559,639.66</b>	<b>439,352,513,795.67</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	-	<b>256,053,549.12</b>
<b>31200</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	-	<b>256,053,549.12</b>
<b>31220</b>	<b>Гадаад валют</b>	-	<b>256,053,549.12</b>
31222	Монгол банк дахь харилцах	-	256,053,549.12
<b>32</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ</b>	<b>144,465,837.58</b>	<b>58,225,796.28</b>
<b>32100</b>	<b>Үнэт цаас</b>	<b>144,465,837.58</b>	<b>58,225,796.28</b>
32110	Төгрөг	144,465,837.58	58,225,796.28
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>257,870,645,277.07</b>	<b>269,428,558,009.12</b>
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	1,408,922.39	4,663,787.05
33101	Цалингийн авлага	1,342,922.39	2,008,857.45
33102	НДШ-ийн авлага	66,000.00	-
33103	ХАОАТ-ын авлага	-	2,654,929.60
33300	Татаас, санхүүжилтийн авлага	14,243,964.09	-
33400	Зээлийн хүүгийн авлага	221,125.30	90,558.66
<b>33500</b>	<b>Бусад авлага</b>	<b>66,125,433.85</b>	<b>46,875,495.00</b>
33510	Байгууллагаас авах авлага	66,125,433.85	46,875,495.00
<b>33600</b>	<b>Зээлийн авлага</b>	<b>257,788,645,831.44</b>	<b>269,376,928,168.41</b>
<b>33610</b>	<b>Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага</b>	<b>257,788,645,831.44</b>	<b>269,376,928,168.41</b>
33613	Сургалтын төрийн сангийн зээлийн авлага	257,788,645,831.44	269,376,928,168.41
3361301	Гадаад зээлийн авлага /19,70/	89,597,224,081.55	92,345,125,265.28
3361302	Гадаад зээлийн авлага/271/	87,498,759,327.88	104,080,116,364.63
3361303	Хөнгөлөлттэй зээлийн авлага	14,742,396,671.98	14,220,150,377.98
3361304	Оюутан хөгжлийн зээлийн авлага	61,781,999,295.55	58,731,536,160.52
3361305	Оюутан хөгжлийн зээлийн авлага/Эрсдэлийн данс/	4,168,266,454.48	-
<b>34</b>	<b>УРЬДЧИЛГАА</b>	<b>43,012,448,525.01</b>	<b>169,599,625,111.14</b>
34600	Урьдчилж гарсан зардал	43,012,448,525.01	169,599,625,111.14
346001	Урьдчилж гарсан зардал Магистр доктор	4,189,934,730.34	4,893,348,214.13
346002	Урьдчилж гарсан зардал Дэлхийн шилдэг	38,795,696,268.34	55,044,959,878.56
346003	Урьдчилж гарсан зардал	26,817,526.33	3,692,125,112.88
346004	Урьдчилж гарсан зардал /Ерөнхийлөгчийн нэрэмжит тэтгэлэг/	-	62,657,296,203.73
346005	Урьдчилж төлсөн зардал /ЕС-ын нэрэмжит тэтгэлэг, ЗГ-ын тэтгэлэг/	-	13,073,822,747.58
346006	Урьдчилж гарсан зардал /Буцалтгүй тусламж, тэтгэлэг/	-	30,238,072,954.26
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	-	<b>10,051,330.00</b>
<b>35400</b>	<b>Хангамжийн материал</b>	-	<b>10,051,330.00</b>
35410	Бичиг хэргийн материал	-	1,154,050.00
35430	Сэлбэг хэрэгсэл	-	8,750,000.00
35470	Бусад хангамжийн материал	-	147,280.00

Боловсролын зээлийн сангийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн  
гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>191,750,781.02</b>	<b>289,182,019.54</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>191,750,781.02</b>	<b>289,182,019.54</b>
<b>39200</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>81,009,934.43</b>	<b>160,069,192.99</b>
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	145,589,885.00	189,148,635.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(78,787,968.58)	(68,947,806.98)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	36,322,072.00	65,361,847.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(22,114,053.99)	(25,493,482.03)
<b>39300</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>110,740,846.59</b>	<b>129,112,826.55</b>
39301	Программ хангамж	206,280,200.00	245,280,200.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(95,539,353.41)	(116,167,373.45)
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>301,219,310,420.68</b>	<b>439,641,695,815.21</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>14,243,964.09</b>	<b>0.08</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>14,243,964.09</b>	<b>0.08</b>
<b>41300</b>	<b>Өглөг</b>	<b>14,243,964.09</b>	<b>0.08</b>
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	0.08
41312	НДШ-ийн өглөг	-	0.08
<b>41360</b>	<b>Бусад өглөг</b>	<b>14,243,964.09</b>	<b>-</b>
41361	Байгууллагад төлөх өглөг	14,243,964.09	-
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>301,205,066,456.59</b>	<b>439,641,695,815.13</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>301,205,066,456.59</b>	<b>439,641,695,815.13</b>
51100	Засгийн газрын оруулсан капитал	29,809,531.00	29,809,531.00
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө	29,809,531.00	29,809,531.00
<b>51200</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>301,175,256,925.59</b>	<b>439,611,886,284.13</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	297,381,734,360.22	358,311,021,102.77
51220	Тайлант үеийн үр дүн	3,793,522,565.37	81,300,865,181.36
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>301,219,310,420.68</b>	<b>439,641,695,815.21</b>

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>69,652,720,554.24</b>	<b>106,161,818,116.95</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1,131,613,349.92</b>	<b>497,519,801.45</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>1,131,613,349.92</b>	<b>497,519,801.45</b>
120002	Хүүгийн орлого	3,985,994.13	-
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>1,127,627,355.79</b>	<b>434,550,001.45</b>
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,127,627,355.79	434,550,001.45
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	-	62,969,800.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>68,521,107,204.32</b>	<b>105,664,298,315.50</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>68,521,107,204.32</b>	<b>105,664,298,315.50</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	68,521,107,204.32	105,664,298,315.50
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>66,144,049,338.90</b>	<b>25,147,244,747.24</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>66,144,049,338.90</b>	<b>25,147,244,747.24</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,100,677,403.44</b>	<b>1,680,719,390.50</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>646,400,055.44</b>	<b>1,077,313,123.54</b>
210101	Үндсэн цалин	396,059,354.40	687,161,410.47
210102	Нэмэгдэл	135,118,298.11	179,327,019.71
210103	Унаа хоолны хөнгөлөлт	63,140,000.00	120,854,590.91
210104	Урамшуулал	52,082,402.93	89,970,102.45
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>83,269,983.03</b>	<b>137,290,969.57</b>
210201	Тэтгэврийн даатгал	57,363,928.39	95,427,716.23
210202	Тэтгэмжийн даатгал	6,748,697.59	11,100,618.54
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,183,357.92	5,408,409.37
210204	Ажилгүйдлийн даатгал	1,270,363.60	5,081,188.08
210205	Эрүүл мэндийн даатгал	12,703,635.53	20,273,037.35
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>215,130,785.00</b>	<b>276,032,561.55</b>
210304	Байрны түрээс	215,130,785.00	276,032,561.55
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>22,394,563.65</b>	<b>26,767,685.74</b>
210401	Бичиг хэрэг	8,290,000.00	7,112,950.00
210402	Тээвэр, шатахуун	-	400,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	12,244,563.65	15,277,565.74
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,860,000.00	3,977,170.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>1,722,200.00</b>	<b>1,065,800.00</b>
210604	Урсгал засвар	1,722,200.00	1,065,800.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>-</b>	<b>338,900.00</b>
210702	Дотоод албан томилолт	-	338,900.00

Боловсролын зээлийн сангийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн  
гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>88,466,611.72</b>	<b>107,034,275.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	55,442,111.72	98,510,275.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	33,024,500.00	8,524,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>43,293,204.60</b>	<b>54,876,075.10</b>
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	43,293,204.60	54,876,075.10
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>65,043,371,935.46</b>	<b>23,466,525,356.74</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>52,288,592,325.22</b>	<b>7,537,372,055.91</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	5,000,000.00	-
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	52,253,024,907.22	7,502,925,091.69
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	30,287,418.00	34,166,964.22
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	280,000.00	280,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>12,754,779,610.24</b>	<b>15,929,153,300.83</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	57,365,242.78	15,338,772,320.12
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	4,260,259.15	1,921,661.95
213306	Улсын төсвийн орлогод төвлөрүүлэх шилжүүлэг	12,693,154,108.32	588,459,318.76
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>3,508,671,215.34</b>	<b>81,014,573,369.72</b>
<b>IV</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН</b>	<b>369,664,445.52</b>	<b>649,231,583.24</b>
<b>14</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГО</b>	<b>369,664,445.52</b>	<b>649,231,583.24</b>
145	Бусад орлого (олз)	369,664,445.52	649,231,583.24
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	369,664,445.52	649,231,583.24
<b>V</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>84,813,095.48</b>	<b>362,939,771.60</b>
<b>23</b>	<b>Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл</b>	<b>839,984.76</b>	<b>-</b>
230	Дотоодын зах зээлээс санхүүжих эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл	839,984.76	-
230001	Эргэж төлөгдөх зээл	839,984.76	-
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ</b>	<b>83,973,110.72</b>	<b>362,939,771.60</b>
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	46,666.38
225004	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	83,973,110.72	362,893,105.22
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>3,793,522,565.38</b>	<b>81,300,865,181.36</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>81,301,252,887.41</b>	<b>120,919,952,281.30</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1,141,861,319.88</b>	<b>696,884,863.89</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>1,141,861,319.88</b>	<b>696,884,863.89</b>
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>1,141,861,319.88</b>	<b>696,884,863.89</b>
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,141,861,319.88	696,884,863.89
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>80,159,391,567.53</b>	<b>120,223,067,417.41</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>80,155,131,308.38</b>	<b>120,221,145,755.46</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	68,521,107,204.32	105,664,298,315.50
131004	Төсөв болон дамжуулан зээлдүүлсэн зээлээс эргэж төлөгдөх	11,634,024,104.06	14,556,847,439.96
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>4,260,259.15</b>	<b>1,921,661.95</b>
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	4,260,259.15	1,921,661.95
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>66,105,455,515.58</b>	<b>104,315,515,749.36</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>66,105,455,515.58</b>	<b>104,315,515,749.36</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,047,839,616.03</b>	<b>1,667,495,690.47</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>651,874,574.30</b>	<b>1,079,602,446.52</b>
210101	Үндсэн цалин	402,045,326.92	692,976,559.71
210102	Нэмэгдэл	134,749,256.89	177,844,522.64
210103	Унаа хоолны хөнгөлөлт	63,059,578.17	120,194,092.61
210104	Урамшуулал	52,020,412.32	88,587,271.56
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>83,269,983.03</b>	<b>137,342,286.31</b>
210201	Тэтгэврийн даатгал	57,363,928.39	95,455,874.40
210202	Тэтгэмжийн даатгал	6,748,697.59	11,194,129.31
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,832,193.89	5,399,064.73
210204	Ажилгүйдлийн даатгал	1,270,363.60	5,071,843.84
210205	Эрүүл мэндийн даатгал	12,054,799.56	20,221,374.03
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>212,068,383.33</b>	<b>302,075,096.90</b>
210304	Байрны түрээс	212,068,383.33	302,075,096.90
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>25,523,363.65</b>	<b>28,321,010.74</b>
210401	Бичиг хэрэг	8,290,000.00	8,267,000.00
210402	Тээвэр, шатахуун	-	400,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	12,244,563.65	15,529,560.74
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,988,800.00	4,124,450.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>1,762,200.00</b>	<b>1,065,800.00</b>
210604	Урсгал засвар	1,762,200.00	1,065,800.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>-</b>	<b>338,900.00</b>
210702	Дотоод албан томилолт	-	338,900.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>73,341,111.72</b>	<b>118,750,150.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	40,316,611.72	101,476,150.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	33,024,500.00	17,274,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>65,057,615,899.55</b>	<b>102,648,020,058.89</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>52,288,592,325.22</b>	<b>86,713,469,174.33</b>

Боловсролын зээлийн сангийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн  
гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	5,000,000.00	-
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	52,253,024,907.22	86,679,022,210.11
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	30,287,418.00	34,166,964.22
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	280,000.00	280,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>12,769,023,574.33</b>	<b>15,934,550,884.56</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	71,609,206.87	15,344,169,903.85
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	4,260,259.15	1,921,661.95
213306	Улсын төсвийн орлогод төвлөрүүлэх шилжүүлэг	12,693,154,108.32	588,459,318.76
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>15,195,797,371.83</b>	<b>16,604,436,531.94</b>
<b>V</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>137,693,350.72</b>	<b>69,884,180.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>137,693,350.72</b>	<b>69,884,180.00</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ</b>	<b>137,693,350.72</b>	<b>69,884,180.00</b>
225004	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	83,973,110.72	-
2251	Үндсэн хөрөнгө олж бэлтгэхэд төлсөн	53,720,240.00	-
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	53,720,240.00	69,884,180.00
<b>VI</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>(137,693,350.72)</b>	<b>(69,884,180.00)</b>
<b>9</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН</b>	<b>1,736,412.75</b>	<b>40,746,660.48</b>
<b>14</b>	<b>Бусад эх үүсвэр</b>	<b>1,736,412.75</b>	<b>40,746,660.48</b>
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	1,736,412.75	40,746,660.48
<b>10</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>15,060,900,612.86</b>	<b>16,319,245,463.30</b>
<b>23</b>	<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	<b>15,060,900,612.86</b>	<b>16,319,245,463.30</b>
230	Дотоодын зах зээлээс санхүүжих эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл	15,060,900,612.86	16,319,245,463.30
230001	Эргэж төлөгдөх зээл	15,060,900,612.86	16,319,245,463.30
<b>VII</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VII)</b>	<b>(15,059,164,200.11)</b>	<b>(16,278,498,802.82)</b>
<b>VIII</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	<b>(1,060,179.00)</b>	<b>256,053,549.12</b>
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,060,179.00	-
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	256,053,549.12

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	29,809,531.00	-	308,454,489,516.71	308,484,299,047.71
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(11,072,755,156.49)	(11,072,755,156.49)
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	29,809,531.00	-	297,381,734,360.22	297,411,543,891.22
9	Тайлант үеийн үр дүн	-	-	3,793,522,565.38	3,793,522,565.38
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	29,809,531.00	-	301,175,256,925.59	301,205,066,456.59
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	57,135,764,177.18	57,135,764,177.18
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	29,809,531.00	-	358,311,021,102.77	358,340,830,633.77
19	Тайлант үеийн үр дүн	-	-	81,300,865,181.36	81,300,865,181.36
20	2024 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	29,809,531.00	-	439,611,886,284.13	439,641,695,815.13

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
11000	Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл	-	-	-	
II	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>124,878,477,900.00</b>	<b>90,469,300,617.26</b>	<b>34,409,177,282.74</b>	<b>72.4</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>93,842,148,000.00</b>	<b>88,450,849,044.80</b>	<b>5,391,298,955.20</b>	<b>94.3</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,786,278,000.00</b>	<b>1,737,389,870.47</b>	<b>48,888,129.53</b>	<b>97.3</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>1,123,489,000.00</b>	<b>1,079,602,446.52</b>	<b>43,886,553.48</b>	<b>96.1</b>
210101	Үндсэн цалин	785,713,100.00	692,976,559.71	92,736,540.29	88.2
210102	Нэмэгдэл	197,175,400.00	177,844,522.64	19,330,877.36	90.2
210103	Унаа хоолны хөнгөлөлт	82,874,900.00	120,194,092.61	(37,319,192.61)	145.0
210104	Урамшуулал	57,725,600.00	88,587,271.56	(30,861,671.56)	153.5
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>140,436,100.00</b>	<b>137,342,286.31</b>	<b>3,093,813.69</b>	<b>97.8</b>
210201	Тэтгэврийн даатгал	95,496,600.00	95,455,874.40	40,725.60	100.0
210202	Тэтгэмжийн даатгал	11,234,900.00	11,194,129.31	40,770.69	99.6
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,617,400.00	5,399,064.73	218,335.27	96.1
210204	Ажилгүйдлийн даатгал	5,617,400.00	5,071,843.84	545,556.16	90.3
210205	Эрүүл мэндийн даатгал	22,469,800.00	20,221,374.03	2,248,425.97	90.0
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>302,089,800.00</b>	<b>302,075,096.90</b>	<b>14,703.10</b>	<b>100.0</b>
210304	Байрны түрээс	302,089,800.00	302,075,096.90	14,703.10	100.0
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>28,985,800.00</b>	<b>28,321,010.74</b>	<b>664,789.26</b>	<b>97.7</b>
210401	Бичиг хэрэг	8,267,000.00	8,267,000.00	-	100.0
210402	Тээвэр, шатахуун	948,900.00	400,000.00	548,900.00	42.2
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	15,636,500.00	15,529,560.74	106,939.26	99.3
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,133,400.00	4,124,450.00	8,950.00	99.8
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>51,585,800.00</b>	<b>51,449,980.00</b>	<b>135,820.00</b>	<b>99.7</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	31,920,000.00	31,784,205.00	135,795.00	99.6
210602	Тавилга	18,600,000.00	18,599,975.00	25.00	100.0
210604	Урсгал засвар	1,065,800.00	1,065,800.00	-	100.0
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>338,900.00</b>	<b>338,900.00</b>	<b>-</b>	<b>100.0</b>
210702	Дотоод албан томилолт	338,900.00	338,900.00	-	100.0
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>139,352,600.00</b>	<b>138,260,150.00</b>	<b>1,092,450.00</b>	<b>99.2</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	101,838,600.00	101,486,150.00	352,450.00	99.7
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	37,514,000.00	36,774,000.00	740,000.00	98.0
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>92,055,870,000.00</b>	<b>86,713,459,174.33</b>	<b>5,342,410,825.67</b>	<b>94.2</b>
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>92,055,870,000.00</b>	<b>86,713,459,174.33</b>	<b>5,342,410,825.67</b>	<b>94.2</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	92,021,191,100.00	86,679,012,210.11	5,342,178,889.89	94.2
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	34,395,100.00	34,166,964.22	228,135.78	99.3
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	283,800.00	280,000.00	3,800.00	98.7

Боловсролын зээлийн сангийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн  
гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

23	<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	<b>31,036,329,900.00</b>	<b>2,018,451,572.46</b>	<b>29,017,878,327.54</b>	<b>6.5</b>
230001	Эргэж төлөгдөх зээл	31,036,329,900.00	2,018,451,572.46	29,017,878,327.54	6.5
III	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>94,878,477,900.00</b>	<b>90,708,544,677.92</b>	<b>4,169,933,222.08</b>	<b>95.6</b>
31	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>124,878,477,900.00</b>	<b>104,753,285,019.64</b>	<b>20,125,192,880.36</b>	<b>83.9</b>
310001	Улсын төсвөөс санхүүжих	124,878,477,900.00	104,753,285,019.64	20,125,192,880.36	83.9
35	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	-	-	-	
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	-	-	
37	<b>БУСАД ЭХ ҮҮСВЭР</b>	<b>(30,000,000,000.00)</b>	<b>(14,044,740,341.72)</b>	<b>(15,955,259,658.28)</b>	<b>46.8</b>
370001	Төсөв болон дамжуулан зээлдүүлсэн зээлээс эргэж төлөгдөх	(30,000,000,000.00)	(14,044,740,341.72)	(15,955,259,658.28)	46.8
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	239,244,060.66	(239,244,060.66)	
6	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>				
61	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>1</b>	<b>1</b>	<b>-</b>	<b>100.0</b>
610001	Төсвийн байгууллага	1	1	-	100.0
62	<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	<b>32</b>	<b>29</b>	<b>3</b>	<b>90.6</b>
620001	Удирдах ажилтан	1	1	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	31	28	3	90.3

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
II	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>		1,921,661.95
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>		1,921,661.95
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>		1,921,661.95
2133	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>		1,921,661.95
213305	Нэмэлт санхүүжилтийн төвлөрүүлэх шилжүүлэг		1,921,661.95
I	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>		1,921,661.95
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>		1,921,661.95
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>		1,921,661.95
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		1,921,661.95
III	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>		
11000	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
12000	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Боловсролын зээлийн сан нь дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид зохих журмын дагуу суралцагчийн тэтгэлэг, сургалтын төлбөрийн зээл олгох, зээлийг эргэн төлүүлэх ажлыг гүйцэтгэх бөгөөд сангийн хөрөнгийг бүрдүүлэх, уг хөрөнгийг төвлөрүүлэн зарцуулах, тайлагнах үндсэн чиг үүрэгтэй ажиллаж байна.

Боловсролын зээлийн сан нь үйл ажиллагааны эрхэм зорилгоо “Зорилготой, хариуцлагатай оюутан суралцагчдад төрөөс үзүүлэх санхүүгийн дэмжлэгийг шуурхай хүргэхэд оршино” гэж тодорхойлсон байна.

Боловсролын зээлийн сан дараах зорилтуудыг хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнд:

- Монгол Улсын дээд боловсролын сургалтын байгууллагад бакалавр, магистр, докторын зэргийн боловсрол эзэмшихээр суралцаж байгаа, зээлийн шалгуур хангасан Монгол Улсын иргэнд “Оюутны хөгжлийн зээл” олгох, зээлийн эргэн төлөлтийг сайжруулах;
- Гадаад улс оронд суралцах оюутан, суралцагчид сургалтын зээл олгох, Гадаад улсад суралцаж төгссөн оюутан, суралцагчдыг сургалтын зээлийн төлбөрөөс чөлөөлөх, эргэн төлүүлэх;
- Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит сургалтын тэтгэлэг олгох;
- Засгийн газрын нэрэмжит сургалтын тэтгэлэг олгох;
- Буцалтгүй тусламж, тэтгэлэг олгох.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Боловсролын зээлийн сан нь Засгийн газрын тусгай сангийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон бусад хууль тогтоомжид нийцүүлэн сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах үндсэн чиг үүргээ хэрэгжүүлж байна.

Тайлант хугацаанд сангийн үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Засгийн газрын 2024 оны 102 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Гадаадын болон дотоодын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид тэтгэлэг, зээл олгох, эргэн төлүүлэх, буцалтгүй тусламж олгох, дэмжлэг үзүүлэх журам”;
- Засгийн газрын 2024 оны 103 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Багш, багш мэргэжлээр суралцагч болон багш, ажилтны хүүхдийг тэргүүлэх, эрэлттэй мэргэжлээр суралцахад төрөөс дэмжлэг үзүүлэх журам”.

Сангийн удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

#### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Боловсролын зээлийн сангийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус сан нь Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны А/22 дугаар тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг санхүүгийн үйл ажиллагаандаа мөрдөж байгаа боловч бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцээгүй, үйл ажиллагааны онцлогт тохироогүй байна. Бодлогын баримт бичигт зээлийн гэрээний төлбөрийг ямар валютаар тусгах, эргэн төлөлт хийхэд аль ханшийг мөрдөх болон гадаад болон дотоод тэтгэлэг, буцалтгүй тусламжийн бүртгэл, төсвийн гүйцэтгэлийн тайлан бэлтгэх, дотоод хяналтын талаар нарийвчилсан зохицуулалтгүй байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Боловсролын зээлийн сангийн 2024 оны санхүүгийн тайланг УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын 2024 оны А/3 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 138,422,385.4 мянган төгрөгөөр буюу 45.9 хувиар өсжээ.

#### Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	256,053.6	256,053.6
Богино хугацаат хөрөнгө оруулалт	144,465.8	58,225.8	(86,240.0)
Авлага	257,870,645.3	269,428,558.0	11,557,912.7
Урьдчилгаа	43,012,448.5	169,599,625.1	126,587,176.6
Бараа материал	-	10,051.3	10,051.3
Үндсэн хөрөнгө	191,750.8	289,182.0	97,431.2
<b>Нийт хөрөнгө</b>	<b>301,219,310.4</b>	<b>439,641,695.8</b>	<b>138,422,385.4</b>
Өр төлбөр	14,244.0	0.0	(14,244.0)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	301,205,066.4	439,641,695.8	138,436,629.4
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>301,219,310.4</b>	<b>439,641,695.8</b>	<b>138,422,385.4</b>

Дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Оны төгсгөлд төрийн сан дахь валютын дансанд орсон 3 суралцагчийн зээлийн эргэн төлөлтөөр мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 256,053.6 мянган төгрөг болсон;
- Богино хугацаат хөрөнгө оруулалт данс нь сангийн 2016-2017 онуудад арилжааны 5 банкаар дамжуулан олгосон хөнгөлөлттэй зээлийг жилийн 2 хувийн хүүтэй энгийн векселиэр бүртгэсэн ба зээлийн эргэн төлөлтийн 86,240.0 мянган төгрөгөөр буурсан;
- Авлагын дансны өсөлт нь Засгийн газрын 2013 оны 271 дүгээр тогтоолын хүрээнд Дэлхийн шилдэг их сургуульд сангийн зээлээр суралцсан 267 суралцагчийн өмнөх онуудад тооцоолоогүй байсан гадаад валютын ханшийн зөрүү 17,489,697.7 мянган төгрөгийг нөхөн тооцоолсноос шалтгаалсан;
- Нөхцөл заасан буцалтгүй тусламж, тэтгэлэгт 40,350,069.5 мянган төгрөг, Ерөнхийлөгчийн нэрэмжит тэтгэлэгт 39,373,544.5 мянган төгрөг, Засгийн газрын нэрэмжит тэтгэлэгт 6,935,398.1 мянган төгрөг, Дэлхийн шилдэг их сургуульд суралцагчдад 11,970,679.0 мянган төгрөгийг санхүүжүүлж, урьдчилгаа дансанд бүртгэсэн нь үлдэгдэл өсөхөд нөлөөлсөн;

- Боловсролын ерөнхий газраас үнэ төлбөргүй 62,696.8 мянган төгрөгийн хөрөнгө балансаас балансад шилжин ирж, урсгал төсвийн хөрөнгөөр 89,384.1 мянган төгрөгийн биет болон биет бус хөрөнгө худалдан авсан нь үндсэн хөрөнгийн үлдэгдлийг өсгөсөн;
- Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл нь өмнөх онуудад хийгдээгүй байсан 57,135,764.1 мянган төгрөгийн гадаад валютын ханшийн зөрүү болон тайлант үеийн үр дүн 81,300,865.2 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус сангийн 2024 оны төсвийн төсөлд зардал, зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 120,158,168.9 мянган төгрөгөөр тооцон улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас урсгал зардлыг 4,720,309.0 мянган төгрөгөөр нэмж, нийт зардлыг 124,878,477.9 мянган төгрөгөөр баталсан нь төрөөс иргэдэд олгох тэтгэмжийн хүртээмжийг нэмэгдүүлсэнтэй холбоотой байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх “Дээд боловсрол” хөтөлбөрийн 14 арга хэмжээг санхүүжүүлэхээр 124,878,477.9 мянган төгрөгийг улсын төсвөөс, төсөвт төвлөрүүлэх эргэж төлөгдөх цэвэр зээлийг 30,000,000.0 мянган төгрөгөөр төлөвлөж баталсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 104,753,285.0 мянган төгрөгийн санхүүжилт авч, 90,469,300.6 мянган төгрөг зарцуулж, эргэж төлөгдөх цэвэр зээлээс 14,044,740.3 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлэн, 239,244.1 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэлтэй тайлагнасан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 90,469,300.6 мянган төгрөг буюу 72.4 хувьтай байгаа нь Эргэж төлөгдөх зээл зардлыг 29,017,878.3 мянган төгрөгөөр, Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшууллын зардлыг 5,342,178.8 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

			/мянган төгрөгөөр/		
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	1,786,278.0	1,737,389.9	48,888.1	97.3
2	80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж,	34,678.9	34,447.0	231.9	99.3
3	81404 Дамжуулан зээлдүүлсэн зээл	(30,000,000.0)	(14,556,847.4)	(15,443,152.5)	48.5
4	81812 ЗГ-ын гэрээгээр гадаадаас дотоод	2,139,892.0	1,815,601.2	324,290.8	84.8
5	81813 Зарим суралцагч (нэн ядуу, мал	18,430,203.1	16,045,072.2	2,385,130.9	87.1
6	81820 Сургалтын төлбөрийн буцалтгүй	2,084,700.0	2,015,429.5	69,270.5	96.7
7	81826 Багш мэргэжлээр суралцаж буй о	9,669,510.1	9,626,707.0	42,803.1	99.6
8	81828 Орон нутагт хийх багшлах дадлага	154,668.4	154,664.1	4.3	100.0
9	81846 Боловсролын зээлийн сан	15,707,272.9	4,348,566.4	11,358,706.5	27.7

Боловсролын зээлийн сангийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

10	81849 Сувилагч мэргэжлээр суралцагсдын тэтгэлэг	6,238,906.8	6,238,899.4	7.4	100.0
11	81851 Гадаадад суралцагсдын зээл	15,329,057.0	11,970,679.1	3,358,377.9	78.1
12	81852 ЗГ-н гэрээгээр гадаадад суралцагсдын тэтгэлэг	4,512,257.7	4,453,696.1	58,561.6	98.7
13	81853 Ерөнхийлөгчийн нэрэмжит тэтгэлэг	40,028,719.5	39,393,544.5	635,175.0	98.4
14	81854 Ерөнхий сайдын нэрэмжит тэтгэлэг	8,762,333.5	6,935,398.1	1,826,935.4	79.2

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар Оюутны хөгжлийн зээлийн 1,921.6 мянган төгрөгийн хүүгийн орлого орсныг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Боловсролын зээлийн сангийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн сангийн үйл ажиллагааг сайжруулах зорилгоор гэрээний үүргийн хэрэгжилт, журам, урьдчилгаа дансны бүртгэл, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг, орлого бүрдүүлэлт, сургалтын зээлийн сонгон шалгаруулалт, архивын үйл ажиллагаатай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Үндэсний аудитын газрын Санхүү, нийцлийн аудитын газрын ахлах аудитор А.Даваадорж гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Энхдалай, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар тус тус хэрэгжүүлсэн.

Боловсролын зээлийн сангийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 58 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт хөрөнгийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг их гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны Санхүүгийн байдлын тайлангийн нийт хөрөнгө 301,219,310.4 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 3,012,193.1 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулиар төсвийн байгууллага, түүний албан тушаалтны зарим үйл ажиллагаа, хангамжийг хязгаарласантай холбогдуулан төсвийн урсгал зардлын саналд хуулиар хориглосон, хязгаарласан арга хэмжээг 2024 оны төсвийн төсөлд төлөвлөөгүй бөгөөд гүйцэтгэлээр зарцуулалт гараагүй байна.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар илэрсэн журам, сонгон шалгаруулалт, гэрээний хэрэгжилттэй холбоотой нийт 14 зөрчилд 4 албан шаардлага хүргүүлжээ.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Боловсрол зээлийн сан нь тайлант онд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулбал зохих 21 нэр төрлийн 146 мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн байна.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

**Тайлант онд Сангаас хэрэгжүүлж байгаа тэтгэлгүүд болон Дэлхийн шилдэг их сургуульд зээлээр суралцуулах сонгон шалгаруулалттай холбоотой дараах зохион байгуулалтын алдаа, зөрчлүүд гарсан байна. Үүнд:**

1. Гадаадын сургалтын байгууллагад суралцах суралцагчдын хяналтын тоо батлах тухай Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн А/305 дугаар тушаалын хоёрдугаар хэсгийн Дэлхийн шилдэг их сургуульд суралцагчдад 2024 онд сургалтын зээл олгох хяналтын тоог 70 хүнээр, мөн 2024 оны 08 дугаар сарын 02-ны өдрийн А/18 дугаар тушаалаар уг тоог 90 болгож өөрчлөн баталсан нь журамд заасан I улиралд багтаан тогтоох хугацааг зөрчсөн байна.

Энэ нь Засгийн газрын 2024 оны 102 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Гадаадын болон дотоодын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид тэтгэлэг, зээл олгох, эргэн төлүүлэх, буцалтгүй тусламж олгох, дэмжлэг үзүүлэх журам"-ын 1 дүгээр зүйлийн 1.9-д "Боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр тухайн жил тэтгэлэг, зээл, хөнгөлөлт, буцалтгүй тусламжид хамрагдах суралцагч (магистрын зэргийн өмнөх хэлний бэлтгэл, ахисан түвшний сургалтад суралцах төрийн албан хаагч болон бусад)-ийн хяналтын тоо, санхүүжүүлэх хэмжээг суралцах улсын нэр, сургалтын байгууллага болон мэргэжлээр нь жил бүрийн I улиралд багтаан тогтооно" гэж заасантай нийцэхгүй байна.

2. Боловсролын зээлийн сан нь суралцах чадварын ерөнхий үнэлгээний шалгалтын агуулга, хамрах хүрээний талаар боловсролын үнэлгээ, арга зүйн байгууллагатай зөвшилцсөн нь анхан шатны баримтаар нотлогдоогүй бөгөөд тухайн жилийн 3 дугаар сард багтаан олон нийтэд нээлттэй, ил тод зарлаагүй байна.

Энэ нь Засгийн газрын 2024 оны 102 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Гадаадын болон дотоодын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид тэтгэлэг, зээл олгох, эргэн төлүүлэх, буцалтгүй тусламж олгох, дэмжлэг үзүүлэх журам"-ын 11 дүгээр зүйлийн 11.15-д "Сан суралцах чадварын ерөнхий үнэлгээний шалгалтын агуулга, хамрах хүрээний талаар боловсролын үнэлгээ, арга зүйн байгууллагатай зөвшилцөж, жил бүрийн 03 дугаар сард нээлттэй, ил тод зарлана" гэж заасантай нийцээгүй байна.

3. Боловсролын үнэлгээний төвийн 2024 оны 9 дүгээр сарын 27-ны өдрийн 01/346 дугаар албан бичгээр Элсэлтийн шалгалтад хамрагдсан суралцагчдаас шалгуур хангасан болон сум, хороондоо тэргүүлсэн 338 суралцагчийн мэдээллийг Боловсролын сайдад журамд заасан хугацаанаас хоцруулан хүргүүлсэн байна.

Энэ нь Засгийн газрын 2024 оны 102 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Гадаадын болон дотоодын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид тэтгэлэг, зээл олгох, эргэн төлүүлэх, буцалтгүй тусламж олгох, дэмжлэг үзүүлэх журам"-ын 3 дугаар

зүйлийн 3.13-т "Боловсролын үнэлгээ, арга зүйн байгууллага элсэлтийн шалгалт зохион байгуулагдсаны дараа энэ журмын 3.5.2-т заасан шаардлага хангасан суралцагчийн нэрсийн жагсаалтыг сум, хороо бүрээр гаргаж, боловсролын асуудал хариуцсан орон нутгийн болон улсын бүртгэлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад тухайн жилийн 07 дугаар сарын 20-ны өдрийн дотор хүргүүлнэ" гэж заасантай нийцэхгүй байна.

4. Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны "Ажлын хэсэг байгуулах тухай" А/221 дүгээр тушаалаар Боловсролын зээлийн сангийн санхүүжилтээр 2024-2025 оны хичээлийн жилд гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад зээлээр суралцах хүсэлтэй иргэдийн сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулах чиг үүрэг бүхий ажлын хэсэг болон Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны "Ажлын хэсэг байгуулах тухай" А/222 дугаар тушаалаар Гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад Монгол улсын Засгийн газрын тэтгэлгээр магистр, докторын үндсэн хөтөлбөрт 2024-2025 оны хичээлийн жилд суралцах хүсэлтэй иргэдийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг тус тус томилсон байна. Сонгон шалгаруулалт тус бүрийн ажлын хэсэгт Авлигатай тэмцэх газрын төлөөллийг оруулаагүй байна.

Энэ нь Засгийн газрын 2024 оны 102 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Гадаадын болон дотоодын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид тэтгэлэг, зээл олгох, эргэн төлүүлэх, буцалтгүй тусламж олгох, дэмжлэг үзүүлэх журам"-ын 11 дүгээр зүйлийн 11.8-д "Боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр гадаадын сургалтын байгууллагад суралцах суралцагчийн сонгон шалгаруулалтын үйл ажиллагааг зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсгийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Авлигатай тэмцэх газар, Тагнуулын ерөнхий газар, холбогдох төрийн захиргааны төв байгууллага, төрийн өмчийн их, дээд сургууль, сан, төрийн бус болон мэргэжлийн байгууллагын төлөөллөөс бүрдсэн 13 гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулна" гэж заасантай нийцэхгүй байна.

5. Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны А/17, А/221, А/222, дүгээр тушаалаар батлагдсан сонгон шалгаруулалтын 3 ажлын хэсгийн гишүүд нь "Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл" гаргаагүй байна.

Энэ нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-т "Энэ хуулийн үйлчлэлд Авлигын эсрэг хуулийн 4 дүгээр зүйлд заасан албан тушаалтан хамаарна" гэж заасантай нийцэхгүй байна. Жич: /Авлигын эсрэг хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-т "Доор дурдсан этгээд энэ хуулийн үйлчлэлд хамаарна: 4.1.8.эрх бүхий байгууллагаас баталсан жагсаалтад заасан албан тушаалтан"/

6. Монгол улсын Засгийн газрын тэтгэлгээр магистр, докторын үндсэн хөтөлбөрт 2024-2025 оны хичээлийн жилд суралцах хүсэлтэй Монголд оршин сууж байгаа иргэдээс суралцах чадварын шалгалтыг цахимаар зохион байгуулалгүй танхимд ярилцлагаар авсан байна.

Энэ нь Засгийн газрын 2024 оны 102 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Гадаадын болон дотоодын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид тэтгэлэг, зээл олгох, эргэн төлүүлэх, буцалтгүй тусламж олгох, дэмжлэг үзүүлэх журам"-ын 11 дүгээр зүйлийн 11.4-т "Тэтгэлэг, зээл, хөнгөлөлт, буцалтгүй тусламжаар дотоодын сургалтын байгууллагад суралцах сонгон шалгаруулалтыг жил бүрийн I, III улиралд, энэ журмын гурав дахь хэсэгт зааснаас бусад гадаадын сургалтын байгууллагад суралцах сонгон

шалгаруулалтыг жил бүрийн II улиралд цахимаар зохион байгуулна" гэж заасантай нийцээгүй байна.

7. Журамд заасан хугацаанд баримт бичгийг дутуу бүрдүүлсэн 120189, 120239 бүртгэлийн дугаартай 2 оролцогчийг сонгон шалгаруулалтад тэнцүүлсэн байна.

Энэ нь Засгийн газрын 2024 оны 102 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Гадаадын болон дотоодын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид тэтгэлэг, зээл олгох, эргэн төлүүлэх, буцалтгүй тусламж олгох, дэмжлэг үзүүлэх журам"-ын 11 дүгээр зүйлийн 11.6-д "Тэтгэлэг, зээл, хөнгөлөлт, буцалтгүй тусламжид хамрагдах хүсэлтийг дотоодын сургалтын байгууллагад суралцах бол сургалтын байгууллагадаа, гадаадын сургалтын байгууллагад суралцах бол санд сонгон шалгаруулалтын заасан хугацаанд гаргана" гэж заасантай нийцэхгүй байна.

8. Duke-ийн судалгааны болон академик хөтөлбөрүүдийг ашигладаг ч Duke University-ийн албан ёсны эрэмбэд багтдаггүй Duke Kunshan University-ийн урилгатай 120025 бүртгэлийн дугаартай оролцогчийг сонгон шалгаруулсан байна.

Энэ нь Засгийн газрын 2024 оны 102 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Гадаадын болон дотоодын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид тэтгэлэг, зээл олгох, эргэн төлүүлэх, буцалтгүй тусламж олгох, дэмжлэг үзүүлэх журам"-ын 10 дугаар зүйлийн 10.7-д "Гадаадын сургалтын байгууллагад суралцагч дараах шаардлага хангасан байна: 10.7.5.дэлхийн шилдэг их сургуулиудын зэрэглэл тогтоодог олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн "Times Higher Education World University Rankings", эсхүл "Academic Ranking of World Universities" байгууллагын сүүлд тогтоосон эрэмбийн жагсаалтын эхний 20-д багтсан сургалтын байгууллагад бакалаврын үндсэн хөтөлбөрөөр суралцах урилга авсан бол мэргэжил харгалзахгүй, 21-50-д багтсан сургалтын байгууллагад бакалаврын үндсэн хөтөлбөрөөр суралцах урилга авсан бол тэргүүлэх, эсхүл эрэлттэй мэргэжлийн чиглэлээр суралцах" гэж заасантай нийцэхгүй байна.

9. Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны "Ажлын хэсэг байгуулах тухай" А/221, А/222 дугаар тушаалаар томилогдсон 2 ажлын хэсэг нь сонгон шалгаруулалтын үр дүнг Ажлын албаны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчид тус тус хугацаа хоцроон 2024 оны 07 дугаар сарын 08-ны өдөр хүлээлгэн өгсөн байна.

Энэ нь Засгийн газрын 2024 оны 102 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Гадаадын болон дотоодын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид тэтгэлэг, зээл олгох, эргэн төлүүлэх, буцалтгүй тусламж олгох, дэмжлэг үзүүлэх журам"-ын 11 дүгээр зүйлийн 11.4-т "Тэтгэлэг, зээл, хөнгөлөлт, буцалтгүй тусламжаар дотоодын сургалтын байгууллагад суралцах сонгон шалгаруулалтыг жил бүрийн I, III улиралд, энэ журмын гурав дахь хэсэгт зааснаас бусад гадаадын сургалтын байгууллагад суралцах сонгон шалгаруулалтыг жил бүрийн II улиралд цахимаар зохион байгуулна" гэж заасантай нийцээгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Сангийн хөрөнгөөр зээлээр болон тэтгэлгээр суралцах хүсэлтэй оролцогчдын сонгон шалгаруулалтыг зохион байгуулахад гаргасан алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх талаар албан шаардлага хүргүүлсэн.

**Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 102 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Гадаадын болон дотоодын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид тэтгэлэг, зээл олгох, эргэн төлүүлэх, буцалтгүй тусламж олгох, дэмжлэг үзүүлэх журам"-д дараах зохицуулалт дутмаг байна. Үүнд:**

10. Зээл авсан суралцагчид сургуулиа төгссөний дараа Монгол Улсад заавал ирж ажиллах үүрэг хүлээхтэй холбоотой нарийвчилсан зохицуулалт дутмаг байгаа нь төгсөгчид эх орондоо эргэн ирж, нийгэм, эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулах, дэвшилтэт шинэ санаа, судалгаа, инновацыг хөгжүүлэх үндсэн зорилгыг хангахгүй байх, төсөв үргүй зарцуулагдах эрсдэлийг бий болгож байна.

Энэ нь Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 3-т "Бүх шатны боловсролын тогтолцоо, агуулгын нэгдмэл бодлого боловсруулж хэрэгжүүлнэ", Дээд боловсролын тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1-т "Дээд боловсролын зорилго нь нийгэм, эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулах, дэвшилтэт шинэ санаа, судалгаа, инновацыг хөгжүүлэх, бүтээлчээр ашиглах, олон соёлын орчинд ажиллаж, амьдрах чадвартай, ёс суртахуунтай иргэнийг бэлтгэхэд оршино", Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.4-т "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх" гэж заасантай нийцэхгүй байна.

11. Монгол Улсын Засгийн газрын тэтгэлгээр магистр, докторын үндсэн хөтөлбөрт хамрагдах суралцагчдыг сонгон шалгаруулах шалгуурт олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн их сургуулиудын эрэмбэ, сургалтын чанарын талаар зохицуулалтгүй байна. Үүний улмаас сургалтын чанар хангалтгүй их, дээд сургуулиуд тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдах, төсөв үргүй зарцуулагдах эрсдэл үүсэж болзошгүй юм.

Энэ нь Дээд боловсролын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.12-т "Хөтөлбөрийн магадлан итгэмжлэл, дээд боловсролын сургалтын байгууллагын эрэмбэ, чансааны үзүүлэлт тухайн байгууллагын суралцагчид хуульд заасан дэмжлэг, зээл, тэтгэлэг олгох үндэслэл болно", Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.4-т "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх" гэж заасантай нийцэхгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 102 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Гадаадын болон дотоодын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид тэтгэлэг, зээл олгох, эргэн төлүүлэх, буцалтгүй тусламж олгох, дэмжлэг үзүүлэх журам"-д зарим нарийвчилсан зохицуулалт дутмаг байгаа асуудлаар дээд шатны төсөв захирагчид санал хүргүүлж шийдвэрлүүлэх талаар албан шаардлага хүргүүлсэн.

12. Сангийн зээлээр суралцсан болон суралцаж буй магистр, доктор, бакалаврын түвшний суралцагчдын барьцаалсан үл хөдлөх хөрөнгийн эрхийн доголдолтой эсэх талаар судалгаа хийгдээгүй бөгөөд Улсын Бүртгэлийн Ерөнхий Газраас тодруулга авах ажиллагаа хийгдээгүй байна.

Энэ нь Иргэний хуулийн 156 дугаар зүйлийн 156.2-т "Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны гэрээг, улсын бүртгэлд бүртгүүлэх бөгөөд гэрээнд талуудын нэр, оршин суугаа /оршин байгаа/ газар, барьцаагаар хангагдах шаардлага, түүний хэмжээ, үүргийг хангах хугацаа, барьцааны зүйл, түүний байгаа газар, үнийг заана", 156.3-т "Энэ хуулийн 156.1, 156.2-т заасан шаардлагыг хангаагүй гэрээ хүчин төгөлдөр бус байна", 158.2-т "Үүрэг гүйцэтгэгч үүрэг гүйцэтгүүлэгчид зохих төлбөр хийснээр барьцаалагчийн шаардлагыг хангасан гэж үзнэ" гэж заасантай нийцэхгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Барьцааны зүйлийн эрхийн доголдолтой эсэх талаар судалгаа хийгээгүй, Улсын Бүртгэлийн Ерөнхий Газраас тодруулга авах ажиллагаа хийгээгүй зөрчлийг арилгах талаар албан шаардлага хүргүүлсэн.

**Суралцагчийн сургалтын төлбөр, амьжиргааны зардалд зориулан олгох хөнгөлөлттэй, эргэн төлөгдөх нөхцөлтэй зээлийн улсын төсвийн оролцоотой эх үүсвэрийг бүрдүүлэх, эргэн төлүүлэх, сургалтын зээлийг хөнгөлөх, чөлөөлөх, хүчингүй болгох журмыг Улсын Их Хурлаас батлаагүй байхад суралцагчтай байгуулсан гэрээнд хөнгөлөлт, чөлөөлөлт, эргэн төлөлтийн асуудлыг шийдвэрлэх зохицуулалт хийсэн, төсвийн хөрөнгийг эрсдэлд оруулсан дараах асуудлууд байна. Үүнд:**

13. Засгийн газрын 2013 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Дэлхийн шилдэг их сургуульд оюутан суралцуулах журам"-ыг үндэслэн байгуулсан Дэлхийн шилдэг их сургуулийн бакалаврын хөтөлбөрт суралцах оюутанд зээл олгох, эргэн төлүүлэх гэрээний 3.7-д "Төгсөгч зээлийг эргэн төлөхтэй холбогдох харилцааг 'Дээд боловсролын санхүүжилт, суралцагчийн нийгмийн баталгааны тухай' хуулийн 8.8-д заасан журмаар зохицуулна" гэж заасан байна.

Энэ зохицуулалтаар бакалаврын боловсрол эзэмшихээр гэрээ байгуулан нийт 40,115,730.23 ам.долларын сургалтын зээл авсан 350 суралцагчийн хөнгөлөлт, чөлөөлөлт, эргэн төлөлтийн асуудлыг хэрхэн шийдвэрлэх нь тодорхойгүй, зээл төлөгдөхгүй байх эрсдэлтэй байна.

14. Засгийн газрын 2012 оны 19 дүгээр тогтоолоор баталсан "Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид сургалтын төлбөрийн болон амьжиргааны зардлын зээл олгох журам"-ыг үндэслэн байгуулсан "Гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдад зээл олгох, эргэн төлүүлэх тухай гэрээ"-ний 3.7-д "Төгсөгч зээлийг эргэн төлөхтэй холбогдох харилцааг 'Дээд боловсролын санхүүжилт, суралцагчийн нийгмийн баталгааны тухай' хуулийн 8.8-д заасан журмаар зохицуулна" гэж заасан байна.

Энэ зохицуулалтаар Магистр, докторын боловсрол эзэмшихээр гэрээ байгуулан 8,988,279.79 ам.долларын зээл авсан 296 суралцагчийн хөнгөлөлт, чөлөөлөлт, эргэн төлөлтийн асуудлыг хэрхэн шийдвэрлэх нь тодорхойгүй, зээл төлөгдөхгүй байх эрсдэлтэй байна.

Энэ нь Дээд боловсролын санхүүжилт, суралцагчийн нийгмийн баталгааны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.8-д "Суралцагчийн сургалтын төлбөр, амьжиргааны зардалд зориулан олгох хөнгөлөлттэй, эргэн төлөгдөх нөхцөлтэй зээлийн улсын төсвийн оролцоотой эх үүсвэрийг бүрдүүлэх, эргэн төлүүлэх, сургалтын зээлийг хөнгөлөх, чөлөөлөх, хүчингүй болгох журмыг Улсын Их Хурал тогтооно", Захиргааны ерөнхий хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.1-т "хуульд үндэслэх", 4.2.5-д "зорилгодоо нийцсэн, бодит нөхцөлд тохирсон, шийдвэр нь үндэслэл бүхий байх" гэж заасантай нийцэхгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Эрх бүхий этгээдийн баталсан шийдвэргүйгээр суралцагчтай байгуулсан гэрээнд хөнгөлөлт, чөлөөлөлт, эргэн төлөлтийн асуудлыг шийдвэрлэх зохицуулалт хийж, төсвийн хөрөнгийг эрсдэлд оруулсан зөрчлийг арилгах талаар албан шаардлага хүргүүлсэн.

#### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

##### **4.5.1 Завсрын аудитын талаар**

Завсрын аудитаар шалгаагдагч байгууллагын 2024 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланг хамруулж, мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, бараа материалын данстад горим, сорил хэрэгжүүлэн, дүнг жилийн эцсийн аудитын тайланд тусгасан.

Аудитаар байгууллага, түүний орчин, дотоод хяналт, дотоод аудитын талаар ойлголт олж аван эрсдэл тодорхойлж, аудитын ерөнхий стратеги боловсруулсан.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар нийт 176,659,468.5 мянган төгрөгийн зөрчил илэрснээс, 98,284.3 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 147,380,658.6 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 14 албан шаардлага хүргүүлж, 29,180,525.6 мянган төгрөгийн зөрчлийг цаашид давтан гаргахгүй байх 8 зөвлөмж өгснийг төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг нотлох баримттай тулган баталгаажуулахад 91.6 хувьтай хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	98,284.3	1	98,284.3	100.0
Албан шаардлага	14	147,380,658.6	13	135,654,665.4	92.8
Зөвлөмж	9	29,180,525.6	8	29,180,525.6	88.9
<b>Нийт дүн</b>	<b>24</b>	<b>176,659,468.5</b>	<b>22</b>	<b>164,933,475.3</b>	<b>91.6</b>

Тус сангийн удирдлага, нягтлан бодогч нь тайлант оны сүүлийн улиралд ажил хүлээн авсан тул өмнөх аудитаар өгсөн гэрээний үүргийн хэрэгжилттэй холбоотой 11,725,993.0 мянган төгрөгийн биелээгүй албан шаардлагын харилцагчийн тоо болон мөнгөн дүнг шинэчлэн дахин албан шаардлага өгөхөөр шийдвэрлэсэн.

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар сангаас зээл авсан суралцагчдын барьцааны зүйлд анхаарал хандуулж горим, сорил хэрэгжүүлэх шаардлагатай байна.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт **33,736,509.3** мянган төгрөгийн зөрчил илэрснээс, 33,641,709.3 мянган төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлж, 94,800.0 мянган төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн 33,736,509.3 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 30,724,316.2 мянган төгрөгөөр давсан тул **Хязгаарлалттай** дүгнэлт өглөө.

### 5.1 Албан шаардлага

1. Засгийн газрын тэтгэлэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тэтгэлэг, Дэлхийн шилдэг их сургуулийн бакалаврын хөтөлбөр болон Сангийн санхүүжилтээр магистр, докторын сургалтад хамрагдсан нийт 68 суралцагч гэрээний үүргээ зөрчсөн байна. Үүнд:

- Засгийн газрын тэтгэлгээр 189,944.99 ам.доллар, 36,000.00 евро-ийн санхүүжилт авсан 4 суралцагч сургуулиа төгссөн боловч Боловсролын зээлийн санд бүртгүүлээгүй;
- Монгол Улсын Ерөнхийлөгчийн тэтгэлгээр 402,882.23 ам.доллар, 129,384.42 евро, 278,375.8 мянган төгрөгийн санхүүжилт авсан 32 суралцагч шалгалтад унасан, сургуулиасаа татгалзсан, хаясан, хөөгдсөн шалтгаанаар гэрээний үүргээ биелүүлээгүй;
- Дэлхийн шилдэг их сургуулийн бакалаврын хөтөлбөрт хамрагдаж 254,931.00 ам.долларын санхүүжилт авсан 3 суралцагч Боловсролын зээлийн санд бүртгүүлээгүй;
- Сангийн санхүүжилтээр магистр, докторын сургалтад хамрагдаж 751,852.97 ам.долларын зээл авсан 29 төгсөгчтэй холбоо тогтоох боломжгүй байна.

Энэ нь Иргэний хуулийн 206 дугаар зүйлийн 206.1-д "Үүргийг тогтоосон газар, хугацаанд нь, зохих ёсоор, шударгаар гүйцэтгэнэ", 208 дугаар зүйлийн 208.1-д "Үүргийг хууль буюу гэрээнд заасан хугацаанд гүйцэтгэнэ", 211 дүгээр зүйлийн 211.1-д "Үүргийн гүйцэтгэлийг үүрэг гүйцэтгүүлэгчид, эсхүл хууль, гэрээ буюу шүүх, арбитрын шийдвэрт заасан эрх бүхий этгээдэд хүлээлгэж өгнө" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Гэрээний үүргээ биелүүлээгүй, зээлдэгчтэй холбоо тогтоогоогүй зөрчлийг арилгаж, цаашид давтан гаргахгүй байх талаар албан шаардлага хүргүүлсэн.

2. Монгол Улсын Ерөнхийлөгчийн тэтгэлгээр 4,558,917.78 ам.доллар, 1,902,319.42 евро, 4,298,444.4 мянган төгрөгийн санхүүжилт авсан 205 суралцагчтай тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Суралцагчидтай тооцоо нийлж баталгаажуулаагүй зөрчлийг арилгаж, цаашид давтан гаргахгүй байх талаар албан шаардлага хүргүүлсэн.

3. Боловсролын зээлийн сангийн санхүүжилтээр Магистр, докторын сургалтад хамрагдаж, 15,807.35 ам.долларын зээл авсан 8 суралцагчийн хувийн хэрэг (анкет, иргэний үнэмлэхийн

хуулбар, сургалтын байгууллагын урилга, гадаад хэлний шалгалтын материал, онооны хуудас, гэрээ, үл хөдлөх хөрөнгийн үнэлгээний тайлан, гэрчилгээний хуулбар, барьцаалбар бүртгэсэн талаарх лавлагаа, дипломын хуулбар болон бусад) сангийн архивд байхгүй байна..

Энэ нь Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.2-т “Байгууллагын зохион байгуулалтын нэгжийн удирдлага болон бичиг хэргийн ажилтан албан хэрэг хөтлөлтийн шатанд баримт бичгийн эмх цэгц, бүрэн бүтэн байдлыг хариуцах бөгөөд тэдгээрт байгууллагын удирдлага хяналт тавина” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Баримт материал үрэгдүүлсэн зөрчлийг арилгах талаар албан шаардлага хүргүүлсэн.

## 5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Илрүүлэлт 1: Өндөр хөгжилтэй орнууд буюу гадаадын сургалтын байгууллагад суралцагсад олгох тэтгэлэг зээл, тусламжийн бүртгэлийн программыг “ЕСМ” ХХК-аар /2016 оны 16/113 тоот гэрээ/ 49,800.0 мянган төгрөгөөр хийлгэсэн байна. Уг гэрээг дүгнэсэн актгүй, Гэрээгээр хийх ажлыг хэрхэн хүлээж авсан нь тодорхой биш, хүлээж авах ажлын хэсэг томилоогүй, хуучирсан эх код дээр бичигдсэн тул хөгжүүлэлт хийлгэхэд хүндрэлтэй, ашиглалт үйлчилгээний гэрээ байгуулаагүй, программ хангамжийн оюуны өмчийг хэн эзэмших талаар гэрээнд тусгаж өгөөгүй, ашиглалтгүй байна.

Илрүүлэлт 2: Гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад бакалавр, магистр, докторын хөтөлбөрт суралцагчдын мэдээллийг бүртгэх программыг “Эрхэс электроникс” ХХК-аар /2019 оны 19/08 тоот гэрээ/ 45,000.0 мянган төгрөгөөр хийлгэсэн байна. Программыг хүлээж авах ажлын хэсгийг томилоогүй 2019 оны 10-р сарын 23-ны өдөр Гадаадад суралцагчдын мэдээллийг бүртгэх программ хангамж хүлээлцэх акт үйлдэж хүлээн авсан. Хүлээж авсан программ хангамжийн эх код, баазын болон Үндсэн хөгжүүлэлтийн үр дүнгийн мэдээлэл байхгүй, аюулгүй ажиллагааны тест хийгдээгүй, системийн хэвийн ажиллагааг шалгаж аваагүй, суралцагчдын мэдээллийг оруулаагүй, нэмэлт хөгжүүлэлт үйлчилгээний гэрээ хийгээгүй, программыг ашиглаагүй байна.

Энэ нь Иргэний хуулийн 206 дугаар зүйлийн 206.1-д "Үүргийг тогтоосон газар, хугацаанд нь, зохих ёсоор, шударгаар гүйцэтгэнэ", 208 дугаар зүйлийн 208.1-д "Үүргийг хууль буюу гэрээнд заасан хугацаанд гүйцэтгэнэ", 211 дүгээр зүйлийн 211.1-д "Үүргийн гүйцэтгэлийг үүрэг гүйцэтгүүлэгчид, эсхүл хууль, гэрээ буюу шүүх, арбитрын шийдвэрт заасан эрх бүхий этгээдэд хүлээлгэж өгнө" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Ашиглалтгүй байгаа программ хангамжийг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт хүсэлт гаргаж шийдвэрлүүлэх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 09 дүгээр сарын 01-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Боловсролын зээлийн сангийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн  
гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Д/д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Засгийн газрын тэтгэлгээр 189,944.99 ам.доллар, 36,000.00 еврогийн санхүүжилт авсан 4 суралцагч сургуулиа төгсөөд Боловсролын зээлийн санд ирж бүртгүүлээгүй, гэрээний үүрэг зөрчигдсөн байна.	1	777,896.7				777,896.7		
2	Монгол Улсын Ерөнхийлөгчийн тэтгэлгээр 402,882.23 ам.доллар, 129,384.42 евро, 278,375.8 мянган төгрөгийн санхүүжилт авсан 32 суралцагч шалгалтад унасан, сургуулиасаа татгалзсан, хаясан, хөөгдсөн шалтгаанаар гэрээний үүрэг зөрчигдсөн байна.		2,130,647.0			1	2,130,647.0		
3	Дэлхийн шилдэг их сургуулийн бакалаврын хөтөлбөрт хамрагдаж 254,931.00 ам.долларын санхүүжилт авсан 3 суралцагч Боловсролын зээлийн санд ирж бүртгүүлээгүй, гэрээний үүрэг зөрчигдсөн байна.		871,981.3				871,981.3		
4	Сангийн санхүүжилтээр Магистр, докторын сургалтад хамрагдаж, 751,852.97 ам.долларын зээл авсан 29 төгсөгчтэй холбоо тогтоож чадаагүй, гэрээний үүрэг зөрчигдсөн байна.		2,571,683.0				2,571,683.0		
5	Монгол Улсын Ерөнхийлөгчийн тэтгэлгээр 4,558,917.78 ам.доллар, 1,902,319.42 евро, 4,298,444.4 мянган төгрөгийн санхүүжилт авсан 205 суралцагчтай тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.	1	26,856,954.1			1	26,856,954.1		

Боловсролын зээлийн сангийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн  
гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

6	Боловсролын зээлийн сангийн санхүүжилтээр Магистр, докторын сургалтад 15,807.35 ам.долларын зээл авсан 8 суралцагчийн хувийн хэрэг (анкет, иргэний үнэмлэхийн хуулбар, сургалтын байгууллагын урилга, гадаад хэлний шалгалтын материал, онооны хуудас, гэрээ, үл хөдлөх хөрөнгийн үнэлгээний тайлан, гэрчилгээний хуулбар, барьцаалбар бүртгэсэн талаарх лавлагаа, дипломын хуулбар болон бусад) сангийн архивд байхгүй байна.	1	432,547.2			1	432,547.2		
7	Өндөр хөгжилтэй орнууд буюу гадаадын сургалтын байгууллагад суралцагсдад олгох тэтгэлэг зээл, тусламжийн бүртгэлийн программыг “ЕСМ” ХХК-аар /2016 оны 16/113 тоот гэрээ/ хийлгэсэн байна. Уг гэрээг дүгнэсэн актгүй, Гэрээгээр хийх ажлыг хэрхэн хүлээж авсан нь тодорхой биш, хүлээж авах ажлын хэсэг томилоогүй, хуучирсан эх код дээр бичигдсэн тул хөгжүүлэлт хийлгэхэд хүндрэлтэй, ашиглалт үйлчилгээний гэрээ байгуулаагүй, программ хангамжийн оюуны өмчийг хэн эзэмших талаар гэрээнд тусгаж өгөөгүй, одоо ашиглахгүй байна		49,800.0						49,800.0
8	Гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад бакалавр, магистр, докторын хөтөлбөрт суралцагчдын мэдээллийг бүртгэх программыг “Эрхэс электроникс” ХХК-аар /2019 оны 19/08 тоот гэрээ/ хийлгэсэн байна. Программыг хүлээж авах ажлын хэсгийг томилолгүй 2019 оны 10-р сарын 23-ны өдөр Гадаадад суралцагчдын мэдээллийг бүртгэх программ хангамж хүлээлцэх акт үйлдэж хүлээн авсан. Хүлээж авсан программ хангамжийн эх код, баазын болон Үндсэн хөгжүүлэлтийн үр дүнгийн мэдээлэл байхгүй, аюулгүй ажиллагааны тест хийгдээгүй, системийн хэвийн ажиллагааг шалгаж аваагүй, тухайн үедээ суралцагчдын мэдээллийг оруулаагүй, нэмэлт хөгжүүлэлт үйлчилгээний гэрээ хийгээгүй, программыг ашиглаагүй байна.	1	45,000.0					1	45,000.0
<b>Дүн</b>		<b>4</b>	<b>33,736,509.3</b>			<b>3</b>	<b>33,641,709.3</b>	<b>1</b>	<b>94,800.0</b>

Боловсролын зээлийн сангийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн  
гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

Д/д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Гадаадын сургалтын байгууллагад суралцах суралцагчдын хяналтын тоо батлах тухай Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн А/305 дугаар тушаалын хоёрдугаар хэсгийн Дэлхийн шилдэг их сургуульд суралцагчдад 2024 онд сургалтын зээл олгох хяналтын тоог 70 хүнээр, мөн 2024 оны 08 дугаар сарын 02-ны өдрийн А/18 дугаар тушаалаар уг тоог 90 болгож өөрчлөн баталсан нь журамд заасан I улиралд багтаан тогтоох хугацааг зөрчсөн байна		0.0				0.0		
2	Боловсролын зээлийн сан нь суралцах чадварын ерөнхий үнэлгээний шалгалтын агуулга, хамрах хүрээний талаар боловсролын үнэлгээ, арга зүйн байгууллагатай зөвшилцсөн нь анхан шатны баримтаар нотлогдоогүй бөгөөд тухайн жилийн 3 дугаар сард багтаан олон нийтэд нээлттэй, ил тод зарлаагүй байна	1	0.0			1	0.0		
3	Боловсролын үнэлгээний төвийн 2024 оны 9-р сарын 27-ны өдрийн 01/346 дугаар албан бичгээр Элсэлтийн шалгалтад хамрагдсан суралцагчдаас шалгуур хангасан болон сум, хороондоо тэргүүлсэн 338 суралцагчийн мэдээллийг Боловсролын сайдад журамд заасан хугацаанаас хоцроон хүргүүлсэн байна		0.0				0.0		

Боловсролын зээлийн сангийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн  
гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

4	Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны "Ажлын хэсэг байгуулах тухай" А/221 дүгээр тушаалаар Боловсролын зээлийн сангийн санхүүжилтээр 2024-2025 оны хичээлийн жилд гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад зээлээр суралцах хүсэлтэй иргэдийн сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулах чиг үүрэг бүхий ажлын хэсэг болон Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны "Ажлын хэсэг байгуулах тухай" А/222 дугаар тушаалаар Гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад Монгол улсын Засгийн газрын тэтгэлгээр магистр, докторын үндсэн хөтөлбөрт 2024-2025 оны хичээлийн жилд суралцах хүсэлтэй иргэдийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг тус тус томилсон байна. Сонгон шалгаруулалт тус бүрийн ажлын хэсэгт Авлигатай тэмцэх газрын төлөөллийг оруулаагүй байна						0.0		0.0		
5	Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны А/17, А/221, А/222, дүгээр тушаалаар батлагдсан сонгон шалгаруулалтын 3 ажлын хэсгийн гишүүд нь "Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл" гаргаагүй байна						0.0		0.0		
6	Монгол улсын Засгийн газрын тэтгэлгээр магистр, докторын үндсэн хөтөлбөрт 2024-2025 оны хичээлийн жилд суралцах хүсэлтэй Монголд оршин сууж байгаа иргэдээс суралцах чадварын шалгалтыг цахимаар зохион байгуулалгүй танхимд ярилцлагаар авсан байна						0.0		0.0		
7	Журамд заасан хугацаанд баримт бичгийг дутуу бүрдүүлсэн 120189, 120239 бүртгэлийн дугаартай 2 оролцогчийг сонгон шалгаруулалтад тэнцүүлсэн байна						0.0		0.0		
8	Duke-ийн судалгааны болон академик хөтөлбөрүүдийг ашигладаг ч Duke University-ийн албан ёсны эрэмбэд багтдаггүй Duke Kunshan University-ийн урилгатай 120025 бүртгэлийн дугаартай оролцогчийг сонгон шалгаруулсан байна						0.0		0.0		
9	Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны "Ажлын хэсэг байгуулах тухай" А/221, А/222 дугаар тушаалаар томилогдсон 2 ажлын хэсэг нь сонгон шалгаруулалтын үр дүнг Ажлын албаны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчид тус тус хугацаа хоцроон 2024 оны 07 дугаар сарын 08-ны өдөр хүлээлгэн өгсөн байна						0.0		0.0		

Боловсролын зээлийн сангийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

10	Зээл авсан суралцагчид сургуулиа төгссөний дараа Монгол Улсад заавал ирж ажиллах үүрэг хүлээхтэй холбоотой нарийвчилсан зохицуулалт дутмаг байгаа нь төгсөгчид эх орондоо эргэн ирж, нийгэм, эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулах, дэвшилтэт шинэ санаа, судалгаа, инновацыг хөгжүүлэх үндсэн зорилгыг хангахгүй байх, төсөв үргүй зарцуулагдах эрсдэлийг бий болгож байна	1	0.0			1	0.0		
11	Монгол Улсын Засгийн газрын тэтгэлгээр магистр, докторын үндсэн хөтөлбөрт хамрагдах суралцагчдыг сонгон шалгаруулах шалгуурт олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн их сургуулиудын эрэмбэ, сургалтын чанарын талаар зохицуулалтгүй байна. Үүний улмаас сургалтын чанар хангалтгүй их, дээд сургуулиуд тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдах, төсөв үргүй зарцуулагдах эрсдэл үүсэж болзошгүй юм	1	0.0			1	0.0		
12	Сангийн зээлээр суралцсан болон суралцаж буй магистр, доктор, бакалаврын түвшний суралцагчдын барьцаалсан үл хөдлөх хөрөнгийн эрх зүйн чадамжтай эсэх нь тодорхойгүй, энэ талаар судалгаа хийгээгүй бөгөөд Улсын Бүртгэлийн Ерөнхий Газраас тодруулга авах ажиллагаа хийгдээгүй байна	1	0.0			1	0.0		

Боловсролын зээлийн сангийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн  
гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

13	<p>Засгийн газрын 2013 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Дэлхийн шилдэг их сургуульд оюутан суралцуулах журам"-ыг үндэслэн байгуулсан Дэлхийн шилдэг их сургуулийн бакалаврын хөтөлбөрт суралцах оюутанд зээл олгох, эргэн төлүүлэх гэрээний 3.7-д "Төгсөгч зээлийг эргэн төлөхтэй холбогдох харилцааг 'Дээд боловсролын санхүүжилт, суралцагчийн нийгмийн баталгааны тухай' хуулийн 8.8-д заасан журмаар зохицуулна" гэж заасан байна. Дээд боловсролын санхүүжилт, суралцагчийн нийгмийн баталгааны тухай хуулийн 8.8-д "Суралцагчийн сургалтын төлбөр, амьжиргааны зардалд зориулан олгох хөнгөлөлттэй, эргэн төлөгдөх нөхцөлтэй зээлийн улсын төсвийн оролцоотой эх үүсвэрийг бүрдүүлэх, эргэн төлүүлэх, сургалтын зээлийг хөнгөлөх, чөлөөлөх, хүчингүй болгох журмыг Улсын Их Хурал тогтооно" гэж заасан боловч тус журмыг тогтоогоогүй байна.</p> <p>Энэ зохицуулалтаар бакалаврын боловсрол эзэмшихээр гэрээ байгуулан нийт 40,115,730.23 ам.долларын сургалтын зээл авсан 350 суралцагчийн хөнгөлөлт, чөлөөлөлт, эргэн төлөлтийн асуудлыг хэрхэн шийдвэрлэх нь тодорхойгүй, зээл төлөгдөхгүй байх эрсдэлтэй байна.</p>	1	137,214,250.6			1	137,214,250.6		
14	<p>Засгийн газрын 2012 оны 19 дүгээр тогтоолоор баталсан "Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид сургалтын төлбөрийн болон амьжиргааны зардлын зээл олгох журам"-ыг үндэслэн байгуулсан "Гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдад зээл олгох, эргэн төлүүлэх тухай гэрээ"-ний 3.7-д "Төгсөгч зээлийг эргэн төлөхтэй холбогдох харилцааг 'Дээд боловсролын санхүүжилт, суралцагчийн нийгмийн баталгааны тухай' хуулийн 8.8-д заасан журмаар зохицуулна" гэж заасан байна. Дээд боловсролын санхүүжилт, суралцагчийн нийгмийн баталгааны тухай хуулийн 8.8-д "Суралцагчийн сургалтын төлбөр, амьжиргааны зардалд зориулан олгох хөнгөлөлттэй, эргэн төлөгдөх нөхцөлтэй зээлийн улсын төсвийн оролцоотой эх үүсвэрийг бүрдүүлэх, эргэн төлүүлэх, сургалтын зээлийг хөнгөлөх, чөлөөлөх, хүчингүй болгох журмыг Улсын Их Хурал тогтооно" гэж заасан боловч тус журмыг тогтоогоогүй байна.</p> <p>Энэ зохицуулалтаар Магистр, докторын боловсрол эзэмшихээр гэрээ байгуулан 8,988,279.79 ам.долларын зээл авсан 296 суралцагчийн хөнгөлөлт, чөлөөлөлт, эргэн төлөлтийн асуудлыг хэрхэн шийдвэрлэх нь тодорхойгүй, зээл төлөгдөхгүй байх эрсдэлтэй байна.</p>	1	30,744,051.4			1	30,744,051.4		
<b>Дүн</b>		<b>4</b>	<b>167,958,302.0</b>			<b>4</b>	<b>167,958,302.0</b>		



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 213/АД/60056

Улаанбаатар хот

СНАГ-2025/020/НА-СТА-ЗГТС

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Боловсролын зээлийн сангийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Сангийн зээлээр суралцсан болон суралцаж буй магистр, доктор, бакалаврын түвшний суралцагчдын барьцаалсан үл хөдлөх хөрөнгийн эрхийн доголдолтой эсэх нь тодорхойгүй, энэ талаар судалгаа хийгээгүй бөгөөд Улсын Бүртгэлийн Ерөнхий Газраас тодруулга авах ажиллагаа хийгдээгүй байна.

Энэ нь Иргэний хуулийн 156 дугаар зүйлийн 156.2-т "Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны гэрээг, улсын бүртгэлд бүртгүүлэх бөгөөд гэрээнд талуудын нэр, оршин суугаа /оршин байгаа/ газар, барьцаагаар хангагдах шаардлага, түүний хэмжээ, үүргийг хангах хугацаа, барьцааны зүйл, түүний байгаа газар, үнийг заана", 156.3-т "Энэ хуулийн 156.1, 156.2-т заасан шаардлагыг хангаагүй гэрээ хүчин төгөлдөр бус байна", 158.2-т "Үүрэг гүйцэтгэгч үүрэг гүйцэтгүүлэгчид зохих төлбөр хийснээр барьцаалагчийн шаардлагыг хангасан гэж үзнэ" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

- Барьцааны зүйлийн эрхийн доголдолтой эсэх нь тодорхойгүй, энэ талаар судалгаа хийгээгүй, Улсын Бүртгэлийн Ерөнхий Газраас тодруулга авах ажиллагаа хийгээгүй зөрчлийг арилгах, биелэлтийг 2025 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
- Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Боловсролын зээлийн сангийн ажлын албаны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /О.Сийлэгмаа/, нягтлан бодогч /Х.Цэнджав/ нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АХЛАХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ  
Д.ЭНХДАЛАЙ  
А.ДАВААДОРЖ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,  
Утас 51-264230

АТ 9693 9030109  
9023030583

Z:\Alban Shaardlaga\2025\0225 SNAG-23.Docx

1505000447



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 214/АД160056

Улаанбаатар хот

СНАГ-2025/020/НА-СТА-ЗГТС

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Боловсролын зээлийн сангийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ.

Засгийн газрын тэтгэлэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тэтгэлэг, Дэлхийн шилдэг их сургуулийн бакалаврын хөтөлбөр болон Сангийн санхүүжилтээр магистр, докторын сургалтад хамрагдсан нийт 68 суралцагч гэрээний үүргээ зөрчсөн байна. Үүнд:


- Засгийн газрын тэтгэлгээр 189,944.99 ам.доллар, 36,000.00 евро, нийт 777,896,680.00 /Долоон зуун далан долоон сая найман зуун ерэн зургаан мянга зургаан зуун наян/ төгрөгийн санхүүжилт авсан 4 суралцагч сургуулиа төгссөн боловч Боловсролын зээлийн санд бүртгүүлээгүй;
- Монгол Улсын Ерөнхийлөгчийн тэтгэлгээр 402,882.23 ам.доллар, 129,384.42 евро, 278,375,850.00 төгрөг, нийт 2,130,647,026.00 /Хоёр тэрбум нэг зуун гучин сая зургаан зуун дөчин долоон мянга хорин зургаан/ төгрөгийн санхүүжилт авсан 32 суралцагч шалгалтад унасан, сургуулиасаа татгалзсан, хаясан, хөөгдсөн шалтгаанаар гэрээний үүргээ биелүүлээгүй;
- Дэлхийн шилдэг их сургуулийн бакалаврын хөтөлбөрт хамрагдаж 254,931.00 /Хоёр зуун тавин дөрвөн мянга есөн зуун гучин нэгэн/ ам.долларын санхүүжилт авсан 3 суралцагч Боловсролын зээлийн санд бүртгүүлээгүй;
- Сангийн санхүүжилтээр магистр, докторын сургалтад хамрагдаж 751,852.97 долоон зуун тавин нэгэн мянга найман зуун тавин хоёр доллар ерөн долоон цент/ам.долларын зээл авсан 29 төгсөгчтэй холбоо тогтоох боломжгүй байна.

Энэ нь Иргэний хуулийн 206 дугаар зүйлийн 206.1-д "Үүргийг тогтоосон газар, хугацаанд нь, зохих ёсоор, шударгаар гүйцэтгэнэ", 208 дугаар зүйлийн 208.1-д "Үүргийг хууль буюу гэрээнд заасан хугацаанд гүйцэтгэнэ", 211 дүгээр зүйлийн 211.1-д "Үүргийн гүйцэтгэлийг үүрэг гүйцэтгүүлэгчид, эсхүл хууль, гэрээ буюу шүүх, арбитрын шийдвэрт заасан эрх бүхий этгээдэд хүлээлгэж өгнө" гэж заасантай нийцэхгүй байна..

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Гэрээний үүрэг хэрэгжүүлээгүй, зээлдэгчтэй холбоо тогтоогоогүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2025 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Боловсролын зээлийн сангийн ажлын албаны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /О.Сийлэгмаа/, нягтлан бодогч /Х.Цэнджав/ нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**  
САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АХЛАХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ  
Д.ЭНХДАЛАЙ  
А.ДАВААДОРЖ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 215/АМ60056

Улаанбаатар хот

СНАГ-2025/020/НА-СТА-ЗГТС

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Боловсролын зээлийн сангийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тэтгэлгээр 4,558,917.78 ам.доллар, 1,902,319.42 евро, 4,298,444,409.71 төгрөг, нийт 26,856,954,098.00 /Хорин зургаан тэрбум найман зуун тавин зургаан сая есөн зуун тавин дөрвөн мянга ерэн найман/ төгрөгийн санхүүжилт авсан 205 суралцагчтай тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасныг зөрчсөн байна.


Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.7-т "авлага, өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Суралцагчидтай тооцоо нийлж баталгаажуулаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2025 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Боловсролын зээлийн сангийн ажлын албаны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /О.Сийлэгмаа/, нягтлан бодогч /Х.Цэнджав/ нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АХЛАХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ  
Д.ЭНХДАЛАЙ  
А.ДАВААДОРЖ





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 216 /АД16005 В

Улаанбаатар хот

СНАГ-2025/020/М.А-СТ.А-ЗГТС

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Боловсролын зээлийн сангийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ.

Боловсролын зээлийн сангийн санхүүжилтээр Магистр, докторын сургалтад хамрагдаж, нийт 15,807.35 /Арван таван мянга найман зуун долоон доллар гучин таван цент/ ам.долларын зээл авсан 8 суралцагчийн хувийн хэрэг (анкет, иргэний үнэмлэхийн хуулбар, сургалтын байгууллагын урилга, гадаад хэлний шалгалтын материал, онооны хуудас, гэрээ, үл хөдлөх хөрөнгийн үнэлгээний тайлан, гэрчилгээний хуулбар, барьцаалбар бүртгэсэн талаарх лавлагаа, дипломын хуулбар болон бусад) сангийн архивд байхгүй байна.

Энэ нь Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.2-т “Байгууллагын зохион байгуулалтын нэгжийн удирдлага болон бичиг хэргийн ажилтан албан хэрэг хөтлөлтийн шатанд баримт бичгийн эмх цэгц, бүрэн бүтэн байдлыг хариуцах бөгөөд тэдгээрт байгууллагын удирдлага хяналт тавина” гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.11-д “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Баримт, материал үрэгдүүлсэн зөрчлийг арилгаж, биелэлтийг 2025 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Боловсролын зээлийн сангийн ажлын албаны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /О.Сийлэгмаа/, нягтлан бодогч /Х.Цэнджав/ нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АХЛАХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ  
Д.ЭНХДАЛАЙ  
А.ДАВААДОРЖ

ATA9693 9006109  
9023030583



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 217/А0160056

Улаанбаатар хот

СНАГ-2025/БЭД/НА-СТА-ЗГТС

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Боловсролын зээлийн сангийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ.

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 102 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Гадаадын болон дотоодын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид тэтгэлэг, зээл олгох, эргэн төлүүлэх, буцалтгүй тусламж олгох, дэмжлэг үзүүлэх журам"-д дараах зохицуулалт дутмаг байна. Үүнд:

1. Зээл авсан суралцагчид сургуулиа төгссөний дараа Монгол Улсад заавал ирж ажиллах үүрэг хүлээхтэй холбоотой нарийвчилсан зохицуулалт дутмаг байгаа нь төгсөгчид эх орондоо эргэн ирж, нийгэм, эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулах, дэвшилтэт шинэ санаа, судалгаа, инновацыг хөгжүүлэх үндсэн зорилгыг хангахгүй байх, төсөв үргүй зарцуулагдах эрсдэлийг бий болгож байна.

Энэ нь Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 3-т "Бүх шатны боловсролын тогтолцоо, агуулгын нэгдмэл бодлого боловсруулж хэрэгжүүлнэ", Дээд боловсролын тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1-т "Дээд боловсролын зорилго нь нийгэм, эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулах, дэвшилтэт шинэ санаа, судалгаа, инновацыг хөгжүүлэх, бүтээлчээр ашиглах, олон соёлын орчинд ажиллаж, амьдрах чадвартай, ёс суртахуунтай иргэнийг бэлтгэхэд оршино", Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.4-т "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх" гэж заасантай нийцэхгүй байна.

2. Монгол Улсын Засгийн газрын тэтгэлгээр магистр, докторын үндсэн хөтөлбөрт хамрагдах суралцагчдыг сонгон шалгаруулах шалгуурт олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн их сургуулиудын эрэмбэ, сургалтын чанарын талаар зохицуулалтгүй байна. Үүний улмаас сургалтын чанар хангалтгүй их, дээд сургуулиуд тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдах, төсөв үргүй зарцуулагдах эрсдэл үүсэж болзошгүй байна.

Энэ нь Дээд боловсролын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.12-т "Хөтөлбөрийн магадлан итгэмжлэл, дээд боловсролын сургалтын байгууллагын эрэмбэ, чансааны үзүүлэлт тухайн байгууллагын суралцагчид хуульд заасан дэмжлэг, зээл, тэтгэлэг олгох үндэслэл болно", Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.4-т "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 102 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Гадаадын болон дотоодын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид тэтгэлэг, зээл олгох, эргэн төлүүлэх, буцалтгүй тусламж олгох, дэмжлэг үзүүлэх журам"-д зарим нарийвчилсан зохицуулалт дутмаг байгаа асуудлаар дээд шатны төсөв захирагчид санал хүргүүлж шийдвэрлүүлэх, биелэлтийг 2025 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Боловсролын зээлийн сангийн ажлын албаны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /О.Сийлэгмаа/, нягтлан бодогч /Х.Цэнджав/ нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН**

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АХЛАХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ  
Д.ЭНХДАЛАЙ  
А.ДАВААДОРЖ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 218/АД160056

Улаанбаатар хот

СНАГ-2025/020/И.А-СТА-ЗГТС

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Боловсролын зээлийн сангийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд Сангаас хэрэгжүүлж байгаа тэтгэлгүүд болон Дэлхийн шилдэг их сургуульд зээлээр суралцуулах сонгон шалгаруулалттай холбоотой дараах зохион байгуулалтын алдаа, зөрчлүүд гарсан байна. Үүнд:

1. Гадаадын сургалтын байгууллагад суралцах суралцагчдын хяналтын тоо батлах тухай Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн А/305 дугаар тушаалаар Дэлхийн шилдэг их сургуульд суралцагчдад 2024 онд сургалтын зээл олгох хяналтын тоог 70 хүнээр, мөн 2024 оны 08 дугаар сарын 02-ны өдрийн А/18 дугаар тушаалаар уг тоог 90 болгож өөрчлөн баталсан нь журамд заасан I улиралд багтаан тогтоох хугацааг зөрчсөн байна.

Энэ нь Засгийн газрын 2024 оны 102 дугаар тогтоолоор батлагдсан "Гадаадын болон дотоодын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид тэтгэлэг, зээл олгох, эргэн төлүүлэх, буцалтгүй тусламж олгох, дэмжлэг үзүүлэх журам"-ын 1.9-д "Боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр тухайн жил тэтгэлэг, зээл, хөнгөлөлт, буцалтгүй тусламжид хамрагдах суралцагч (магистрын зэргийн өмнөх хэлний бэлтгэл, ахисан түвшний сургалтад суралцах төрийн албан хаагч болон бусад)-ийн хяналтын тоо, санхүүжүүлэх хэмжээг суралцах улсын нэр, сургалтын байгууллага болон мэргэжлээр нь жил бүрийн I улиралд багтаан тогтооно" гэж заасныг зөрчсөн байна.

2. Боловсролын зээлийн сан нь суралцах чадварын ерөнхий үнэлгээний шалгалтын агуулга, хамрах хүрээний талаар боловсролын үнэлгээ, арга зүйн байгууллагатай зөвшилцсөн нь анхан шатны баримтаар нотлогдоогүй бөгөөд тухайн жилийн 3 дугаар сард багтаан олон нийтэд нээлттэй, ил тод зарлаагүй байна.

Энэ нь Засгийн газрын 2024 оны 102 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Гадаадын болон дотоодын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид тэтгэлэг, зээл олгох, эргэн төлүүлэх, буцалтгүй тусламж олгох, дэмжлэг үзүүлэх журам"-ын 11 дүгээр зүйлийн 11.15-д "Сан суралцах чадварын ерөнхий үнэлгээний шалгалтын агуулга, хамрах хүрээний талаар боловсролын үнэлгээ, арга зүйн байгууллагатай зөвшилцөж, жил бүрийн 03 дугаар сард нээлттэй, ил тод зарлана" гэж заасныг зөрчсөн байна.

3. Боловсролын үнэлгээний төвийн 2024 оны 9 дүгээр сарын 27-ны өдрийн 01/346 дугаар албан бичгээр Элсэлтийн шалгалтад хамрагдсан суралцагчдаас шалгуур хангасан болон сум, хороондоо тэргүүлсэн 338 суралцагчийн мэдээллийг Боловсролын сайдад журамд заасан хугацаанаас хоцруулан хүргүүлсэн байна.

Энэ нь Засгийн газрын 2024 оны 102 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Гадаадын болон дотоодын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид тэтгэлэг, зээл олгох, эргэн төлүүлэх, буцалтгүй тусламж олгох, дэмжлэг үзүүлэх журам"-ын 3 дугаар зүйлийн 3.13-т "Боловсролын үнэлгээ, арга зүйн байгууллага элсэлтийн шалгалт зохион байгуулагдсаны дараа энэ журмын 3.5.2-т заасан шаардлага хангасан суралцагчийн нэрсийн жагсаалтыг сум, хороо бүрээр гаргаж, боловсролын асуудал хариуцсан орон нутгийн болон улсын бүртгэлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад тухайн жилийн 07 дугаар сарын 20-ны өдрийн дотор хүргүүлнэ" гэж заасныг зөрчсөн байна.

4. Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны "Ажлын хэсэг байгуулах тухай" А/221 дүгээр тушаалаар Боловсролын зээлийн сангийн санхүүжилтээр 2024-2025 оны хичээлийн жилд гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад зээлээр суралцах хүсэлтэй иргэдийн сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулах чиг үүрэг бүхий ажлын хэсэг болон Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны "Ажлын хэсэг байгуулах тухай" А/222 дугаар тушаалаар Гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад Монгол улсын Засгийн газрын тэтгэлгээр магистр, докторын үндсэн хөтөлбөрт 2024-2025 оны хичээлийн жилд суралцах хүсэлтэй иргэдийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг тус тус томилсон байна. Сонгон шалгаруулалт тус бүрийн ажлын хэсэгт Авлигатай тэмцэх газрын төлөөллийг оруулаагүй байна.

Энэ нь Засгийн газрын 2024 оны 102 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Гадаадын болон дотоодын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид тэтгэлэг, зээл олгох, эргэн төлүүлэх, буцалтгүй тусламж олгох, дэмжлэг үзүүлэх журам"-ын 11 дүгээр зүйлийн 11.8-д "Боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр гадаадын сургалтын байгууллагад суралцах суралцагчийн сонгон шалгаруулалтын үйл ажиллагааг зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсгийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Авлигатай тэмцэх газар, Тагнуулын ерөнхий газар, холбогдох төрийн захиргааны төв байгууллага, төрийн өмчийн их, дээд сургууль, сан, төрийн бус болон мэргэжлийн байгууллагын төлөөлөөс бүрдсэн 13 гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулна" гэж заасныг зөрчсөн байна.

5. Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны А/17, А/221, А/222, дүгээр тушаалаар батлагдсан сонгон шалгаруулалтын 3 ажлын хэсгийн гишүүд нь "Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл" гаргаагүй байна.

Энэ нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-т "Энэ хуулийн үйлчлэлд Авлигын эсрэг хуулийн 4 дүгээр зүйлд заасан албан тушаалтан хамаарна" гэж заасныг зөрчсөн байна. Жич: /Авлигын эсрэг хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-т "Доор дурдсан этгээд энэ хуулийн үйлчлэлд хамаарна: 4.1.8.эрх бүхий байгууллагаас баталсан жагсаалтад заасан албан тушаалтан"/

6. Монгол улсын Засгийн газрын тэтгэлгээр магистр, докторын үндсэн хөтөлбөрт 2024-2025 оны хичээлийн жилд суралцах хүсэлтэй Монголд оршин сууж байгаа иргэдээс суралцах чадварын шалгалтыг цахимаар зохион байгуулалгүй танхимд ярилцлагаар авсан байна.

Энэ нь Засгийн газрын 2024 оны 102 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Гадаадын болон дотоодын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид тэтгэлэг, зээл олгох, эргэн төлүүлэх, буцалтгүй тусламж олгох, дэмжлэг үзүүлэх журам"-ын 11 дүгээр зүйлийн 11.4-т "Тэтгэлэг, зээл, хөнгөлөлт, буцалтгүй тусламжаар дотоодын сургалтын байгууллагад суралцах сонгон шалгаруулалтыг жил бүрийн I, III улиралд, энэ журмын гурав дахь хэсэгт зааснаас бусад гадаадын сургалтын байгууллагад суралцах

сонгон шалгаруулалтыг жил бүрийн II улиралд цахимаар зохион байгуулна" гэж заасныг зөрчсөн байна.

7. Журамд заасан хугацаанд баримт бичгийг дутуу бүрдүүлсэн 120189, 120239 бүртгэлийн дугаартай 2 оролцогчийг сонгон шалгаруулалтад тэнцүүлсэн байна.

Энэ нь Засгийн газрын 2024 оны 102 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Гадаадын болон дотоодын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид тэтгэлэг, зээл олгох, эргэн төлүүлэх, буцалтгүй тусламж олгох, дэмжлэг үзүүлэх журам"-ын 11 дүгээр зүйлийн 11.6-д "Тэтгэлэг, зээл, хөнгөлөлт, буцалтгүй тусламжид хамрагдах хүсэлтийг дотоодын сургалтын байгууллагад суралцах бол сургалтын байгууллагадаа, гадаадын сургалтын байгууллагад суралцах бол санд сонгон шалгаруулалтын заасан хугацаанд гаргана" гэж заасныг зөрчсөн байна.

8. Duke-ийн судалгааны болон академик хөтөлбөрүүдийг ашигладаг ч Duke University-ийн албан ёсны эрэмбэд багтдаггүй Duke Kunshan University-ийн урилгатай 120025 бүртгэлийн дугаартай оролцогчийг сонгон шалгаруулсан байна.

Энэ нь Засгийн газрын 2024 оны 102 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Гадаадын болон дотоодын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид тэтгэлэг, зээл олгох, эргэн төлүүлэх, буцалтгүй тусламж олгох, дэмжлэг үзүүлэх журам"-ын 10 дугаар зүйлийн 10.7-д "Гадаадын сургалтын байгууллагад суралцагч дараах шаардлага хангасан байна: 10.7.5.дэлхийн шилдэг их сургуулиудын зэрэглэл тогтоодог олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн "Times Higher Education World University Rankings", эсхүл "Academic Ranking of World Universities" байгууллагын сүүлд тогтоосон эрэмбийн жагсаалтын эхний 20-д багтсан сургалтын байгууллагад бакалаврын үндсэн хөтөлбөрөөр суралцах урилга авсан бол мэргэжил харгалзахгүй, 21-50-д багтсан сургалтын байгууллагад бакалаврын үндсэн хөтөлбөрөөр суралцах урилга авсан бол тэргүүлэх, эсхүл эрэлттэй мэргэжлийн чиглэлээр суралцах" гэж заасныг зөрчсөн байна.

9. Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны "Ажлын хэсэг байгуулах тухай" А/221, А/222 дугаар тушаалаар томилогдсон 2 ажлын хэсэг нь сонгон шалгаруулалтын үр дүнг Ажлын албаны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчид тус тус хугацаа хоцроон 2024 оны 07 дугаар сарын 08-ны өдөр хүлээлгэн өгсөн байна.

Энэ нь Засгийн газрын 2024 оны 102 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Гадаадын болон дотоодын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид тэтгэлэг, зээл олгох, эргэн төлүүлэх, буцалтгүй тусламж олгох, дэмжлэг үзүүлэх журам"-ын 11 дүгээр зүйлийн 11.4-т "Тэтгэлэг, зээл, хөнгөлөлт, буцалтгүй тусламжаар дотоодын сургалтын байгууллагад суралцах сонгон шалгаруулалтыг жил бүрийн I, III улиралд, энэ журмын гурав дахь хэсэгт зааснаас бусад гадаадын сургалтын байгууллагад суралцах сонгон шалгаруулалтыг жил бүрийн II улиралд цахимаар зохион байгуулна" гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Сангийн хөрөнгөөр зээлээр болон тэтгэлгээр суралцах хүсэлтэй оролцогчдын сонгон шалгаруулалтыг зохион байгуулахад гаргасан алдаа, зөрчлийг таслан зогсоох, биелэлтийг 2025 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Боловсролын зээлийн сангийн ажлын албаны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /О.Сийлэгмаа/, нягтлан бодогч /Х.Цэнджав/ нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АХЛАХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ  
Д.ЭНХДАЛАЙ  
А.ДАВААДОРЖ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 219/АО160056

Улаанбаатар хот

СНАГ-2025/020/И.А-СТА-ЗГТС

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Боловсролын зээлийн сангийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ.

Суралцагчийн сургалтын төлбөр, амьжиргааны зардалд зориулан олгох хөнгөлөлттэй, эргэн төлөгдөх нөхцөлтэй зээлийн улсын төсвийн оролцоотой эх үүсвэрийг бүрдүүлэх, эргэн төлүүлэх, сургалтын зээлийг хөнгөлөх, чөлөөлөх, хүчингүй болгох журмыг Улсын Их Хурлаас батлаагүй байхад суралцагчтай байгуулсан гэрээнд хөнгөлөлт, чөлөөлөлт, эргэн төлөлтийн асуудлыг шийдвэрлэх зохицуулалт хийсэн, төсвийн хөрөнгийг эрсдэлд оруулсан дараах асуудлууд байна. Үүнд:

1. Засгийн газрын 2013 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Дэлхийн шилдэг их сургуульд оюутан суралцуулах журам"-ыг үндэслэн байгуулсан Дэлхийн шилдэг их сургуулийн бакалаврын хөтөлбөрт суралцах оюутанд зээл олгох, эргэн төлүүлэх гэрээний 3.7-д "Төгсөгч зээлийг эргэн төлөхтэй холбогдох харилцааг 'Дээд боловсролын санхүүжилт, суралцагчийн нийгмийн баталгааны тухай' хуулийн 8.8-д заасан журмаар зохицуулна" гэж заасан байна.

Энэ зохицуулалтаар бакалаврын боловсрол эзэмшихээр гэрээ байгуулан нийт 40,115,730.23 /Дөчин сая нэг зуун арван таван мянга долоон зуун гучин доллар хорин гурван цент/ ам.долларын сургалтын зээл авсан 350 суралцагчийн хөнгөлөлт, чөлөөлөлт, эргэн төлөлтийн асуудлыг хэрхэн шийдвэрлэх нь тодорхойгүй, зээл төлөгдөхгүй байх эрсдэлтэй байна.

2. Засгийн газрын 2012 оны 19 дүгээр тогтоолоор баталсан "Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид сургалтын төлбөрийн болон амьжиргааны зардлын зээл олгох журам"-ыг үндэслэн байгуулсан "Гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдад зээл олгох, эргэн төлүүлэх тухай гэрээ"-ний 3.7-д "Төгсөгч зээлийг эргэн төлөхтэй холбогдох харилцааг 'Дээд боловсролын санхүүжилт, суралцагчийн нийгмийн баталгааны тухай' хуулийн 8.8-д заасан журмаар зохицуулна" гэж заасан байна.

Энэ зохицуулалтаар Магистр, докторын боловсрол эзэмшихээр гэрээ байгуулан 8,988,279.79 /Найман сая есөн зуун наян найман мянга хоёр зуун далан есөн доллар далан есөн цент/ ам.долларын зээл авсан 296 суралцагчийн хөнгөлөлт, чөлөөлөлт, эргэн төлөлтийн асуудлыг хэрхэн шийдвэрлэх нь тодорхойгүй, зээл төлөгдөхгүй байх эрсдэлтэй байна.

Энэ нь Дээд боловсролын санхүүжилт, суралцагчийн нийгмийн баталгааны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.8-д "Суралцагчийн сургалтын төлбөр, амьжиргааны зардалд зориулан олгох хөнгөлөлттэй, эргэн төлөгдөх нөхцөлтэй зээлийн улсын төсвийн оролцоотой эх үүсвэрийг бүрдүүлэх, эргэн төлүүлэх, сургалтын зээлийг хөнгөлөх, чөлөөлөх, хүчингүй болгох журмыг Улсын Их Хурал тогтооно", Захиргааны ерөнхий хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.1-т "хуульд үндэслэх", 4.2.5-д "зорилгодоо нийцсэн, бодит нөхцөлд тохирсон, шийдвэр нь үндэслэл бүхий байх" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Эрх бүхий этгээдийн баталсан шийдвэргүйгээр суралцагчтай байгуулсан гэрээнд хөнгөлөлт, чөлөөлөлт, эргэн төлөлтийн асуудлыг шийдвэрлэх зохицуулалт хийж, төсвийн хөрөнгийг эрсдэлд оруулсан зөрчлийг арилгах, биелэлтийг 2025 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Боловсролын зээлийн сангийн ажлын албаны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /О.Сийлэгмаа/, нягтлан бодогч /Х.Цэнджав/ нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**  
САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АХЛАХ АУДИТОР

